

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ**

2025 оны 4-р сарын 25-ны өдөр



## АГУУЛГА

• Хурлын зар, хэлэлцэх асуудлын жагсаалт .....	4
• Хувьцаа эзэмшигчдийн танилцах боломжтой баримт бичгийн жагсаалт, хугацаа, арга хэлбэр .....	5
• Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн хурлын тогтоол .....	6
• Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг .....	8
• Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой материал	
1. Говь ХК-ийн 2024 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайлан .....	9
- 2024 оны санхүүгийн үр дүн .....	9
- Санхүүжилтийн мэдээлэл.....	15
- Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл .....	16
- Хувьцаа эзэмшигчид.....	19
- Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд болон эцсийн өмчлөгчийн мэдээлэл .....	20
- Дотоод зах зээл.....	21
- Гадаад зах зээл .....	23
- Нэгтгэсэн санхүүгийн тайлан.....	26
2. 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай.....	31
3. ТУЗ-өөс Говь ХК-ийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагаа тайланд өгөх дүгнэлт.....	32
4. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах төсөл.....	34
5. ТУЗ-ийн 2024 оны ажлын тайлан.....	36
6. ТУЗ-ийн 2025 оны цалингийн төсөв.....	46
7. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга.....	47
• Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл.....	53
• Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн.....	57
• Санал авах хуудасны загвар.....	58



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2025 оны 3-р сарын 14-ний өдрийн №04 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал(цаашид “Хурал” гэх)-ыг зарлаж байгаа тул хувьцаа эзэмшигч та бүхнийг оролцохыг урьж байна.

<b>Хурлын өдөр:</b>	2025 оны 4-р сарын 25-ны өдөр, Баасан гараг
<b>Эхлэх цаг:</b>	14:00 цаг (Бүртгэл 13:00 цагт эхэлж 13:55 цагт хаагдахыг анхаарна уу)
<b>Байршил:</b>	ХААН театр (Монгол Улс, УБ хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж-25, Хаан банкны Сөүл оффисын 1-р давхар)
<b>Хурлын хэлбэр:</b>	Танхимаар
<b>Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:</b>	2025 оны 4-р сарын 4-ний өдөр
<b>Хурлаар хэлэлцэх асуудал:</b>	<ul style="list-style-type: none"> <li>• <b>Танилцуулах асуудал</b> <ol style="list-style-type: none"> <li>1. Говь ХК-ийн 2024 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайланг танилцуулах</li> <li>2. 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах</li> </ol> </li> <li>• <b>Хэлэлцэн батлах асуудал</b> <ol style="list-style-type: none"> <li>1. ТУЗ-өөс компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах</li> <li>2. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн батлах</li> <li>3. ТУЗ-ийн 2024 оны ажлын тайлангийн танилцуулга, 2025 оны цалингийн төсвийг батлах</li> <li>4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг сонгон томилох</li> </ol> </li> </ul>
<b>Хурлын материалтай танилцах:</b>	<p>Хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь <b>2025 оны 3-р сарын 24-ний өдрөөс эхлэн</b> дараах арга хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцаж болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас (<a href="http://www.mse.mn/mn/company/354">www.mse.mn/mn/company/354</a>);</li> <li>• Говь ХК-ийн цахим хуудас (<a href="mailto:info.gobi.mn">info.gobi.mn</a>);</li> <li>• Өөрийн харилцаж буй үнэт цаасны компаниасаа цахимаар болон биечлэн очиж;</li> <li>• Говь ХК-ийн Гоёо оффисын байрны 3-р давхарт байрлах ТУЗ-ийн ажлын албаны өрөөнд ажлын өдрүүдийн 08:00-16:00 цагийн хооронд ирж танилцах боломжтой.</li> </ul>
<b>Урьдчилан санал өгөх:</b>	<p>Хурлын материалтай танилцан, саналын хуудсыг бөглөж дараах арга хэлбэрээр <b>2025 оны 4-р сарын 22-ны өдрийн дотор</b> иргэний үнэмлэх (хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ)-ний хуулбарын хамт ирүүлнэ үү:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Өөрийн харилцдаг үнэт цаасны компаниар дамжуулан өгөх;</li> <li>• Говь ХК дээр биечлэн ирж өгөх;</li> <li>• Шуудангаар илгээх (Говь ХК-ийн албан ёсны хаяг);</li> <li>• И-мэйлээр ирүүлэх (<a href="mailto:boardoffice@gobicashmere.com">boardoffice@gobicashmere.com</a>).</li> </ul>
<b>Хурал зохион байгуулах комисстой холбоо барих:</b>	ТУЗ-ийн ажлын албаны утас: 9411-8277, 9499-5750 И-мэйл: <a href="mailto:boardoffice@gobicashmere.com">boardoffice@gobicashmere.com</a>
<b>Говь ХК-ийн албан ёсны хаяг:</b>	Улаанбаатар - 17062, ХУД, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Утас: 7013-9977, Факс: 7014-3081, Шуудангийн хайрцаг: 36/434, Говь ХК



## ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БОЛОМЖТОЙ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ, ХУГАЦАА, АРГА ХЭЛБЭР

1. Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
  - Компанийн 2024 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайлан;
  - 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт;
  - Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл;
  - ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал, бусад зардал;
  - ТУЗ-ийн 2024 оны ажлын тайлан, 2025 оны цалингийн төсөв;
  - ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
  - Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн эсэх тухай хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт;
  - Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо;
  - Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл;
  - Компанийн тухай хуулийн 65.6-д заасан шаардлагатай бусад баримт бичиг.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь **2025 оны 3-р сарын 24-ний өдрөөс эхлэн** дараах арга хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
  - Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас ([www.mse.mn/mn/company/354](http://www.mse.mn/mn/company/354));
  - Говь ХК-ийн цахим хуудас ([info.gobi.mn](mailto:info.gobi.mn));
  - Өөрийн харилцаж буй үнэт цаасны компаниасаа цахимаар болон биечлэн очиж;
  - Говь ХК-ийн Гоёо оффисын байрны 3-р давхарт байрлах ТУЗ-ийн ажлын албаны өрөөнд ажлын өдрүүдийн 08:00-16:00 цагийн хооронд ирж танилцах боломжтой.



# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

GOBI



"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 он 03 сар 11 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Говь ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид "Хурал" гэх)-ыг зарлан хуралдах асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 60.1, 60.2, 60.4, 64.2, 65, 67, 71.1.1, 71.1.3, 76.1.2, Компанийн дүрмийн 6.1.3, 6.1.4, 6.2.7.3, 6.2.7.4 дугаар зүйл заалтуудыг тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

### 1. Хурлын тов

- 1.1. Хурлыг **2025 оны 4-р сарын 25-ны Баасан гарагийн 14:00 цагт** Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж-25, Хаан банкны Сөүл оффисын **ХААН театрт танхимын хэлбэрээр** хуралдуулсугай.

### 2. Хэлэлцэх асуудал, санал хураах журам

- 2.1. Хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтыг **Хавсралт 1-ээр** баталсугай.
- 2.2. Хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцах боломжтой баримт бичгийн жагсаалт, хугацаа, арга хэлбэрийг **Хавсралт 2-оор** баталсугай.
- 2.3. Санал авах хуудасны загварыг **Хавсралт 3-аар** баталсугай.
- 2.4. Санал хураалтыг хурлын үеэр авахаас гадна урьдчилсан байдлаар компанийн шуудангийн хаяг, и-мэйл хаяг болон үнэт цаасны компаниар дамжуулан хүлээн авах ба урьдчилан санал авах сүүлчийн өдрийг **2025 оны 4-р сарын 22-ны өдрөөр** тогтоосугай.

### 3. Бүртгэл, мэдээлэл хүргүүлэх

- 3.1. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2025 оны 4-р сарын 4-ний өдрөөр** тогтоосугай.
- 3.2. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид **2025 оны 3-р сарын 17-ны өдөр** хүргүүлж, Хурлын зарыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын дагуу **2025 оны 3-р сарын 19** болон **4-р сарын 3-ны өдрүүдэд** олон нийтэд зарлахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.
- 3.3. Хурлын зарын хэвлэлийн эхийг **Хавсралт 4-өөр** баталсугай.

### 4. Хурлын баримт бичиг

- 4.1. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг **2025 оны 3-р сарын 24-ний өдрийн дотор** үнэт цаасны компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.

"Говь" ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17062, Монгол улс  
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, И-мэйл: info@gobi.mn, Вэб сайт: www.gobi.mn

GOBI



"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 он 03 сар 11 өдөр

Дугаар 04










Улаанбаатар хот

## 5. Хурлын зохион байгуулалт

- 5.1. Хурлын дэгийг **Хавсралт 5-аар** баталсугай.
- 5.2. Хурлыг ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа даргалсугай.
- 5.3. Хурал зохион байгуулах комиссыг **Хавсралт 6-аар** томилсугай.
- 5.4. Хурлын Тооллогын комиссыг **Хавсралт 7-оор** томилсугай.
- 5.5. Хурлын бэлтгэлийг хангаж, хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичиг, мэдээллийг бэлдэх, дэгийн дагуу зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комиссын даргад үүрэг болгосугай.
- 5.6. Хурлын ирцийг бүртгэж Хурлын даргад мэдээлэх, саналын хурааж, тооллогын үр дүнг нэгтгэн Хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Тооллогын комиссын даргад үүрэг болгосугай.

## 6. Хурлын шийдвэрийн хэрэгжилт

- 6.1. Хурлын шийдвэр болон бусад холбогдох баримт бичиг, тайлан мэдээллийг холбогдох хууль журамд заасан хугацаанд олон нийтэд мэдээлж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:  Ц.БААТАРСАЙХАН  
ТУЗ-ИЙН ГИШҮҮД:  Б.АМАРСАЙХАН  
 Д.ГЭРЭЛМАА  
 А.ЖАРГАЛМАА  
 Н.МӨНХБАТ  
 Ц.ОРГИЛБОЛД  
 Д.ХУЛАН  
 Д.ХҮРЭЛБААТАР  
 Б.ЦЭЭНЯМ

"Говь" ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17062, Монгол улс  
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, И-мэйл: info@gobi.mn, Вэб сайт: www.gobi.mn



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ


Хурлын ирцийг гаргаж хурлын даргад мэдэгдэх <i>Тооллогын комиссын дарга Н.Сайнзул</i>	14:00-14:02
Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах <i>Хурлын дарга Д.Гэрэлмаа</i>	14:02-14:04
Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг танилцуулах <i>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ</i>	14:04-14:06
Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина:	
4.1 Компанийн 2024 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайланг танилцуулах <i>Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан</i>	14:06-14:21
4.2 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах <i>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ</i>	14:21-14:23
4.3 ТУЗ-өөс компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах <i>Хурлын дарга Д.Гэрэлмаа</i>	14:23-14:30
4.4 Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай танилцуулах <i>Хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр</i>	14:30-14:40
4.5 ТУЗ-ийн 2024 оны ажлын тайлан, 2025 оны цалингийн төсвийг танилцуулах <i>Хурлын дарга Д.Гэрэлмаа</i>	14:40-14:55
4.6 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах <i>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ</i>	14:55-15:00
Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт <i>Хүн тус бүр 2 минут /Нийт 20 минут/</i>	15:00-15:20
Санал өгөх зааварчилгаа танилцуулах <i>2 минут</i>	15:20-15:22
Саналын хуудсаар санал авах <i>10 минут</i>	15:22-15:32
Завсарлага /Санал хураалтын дүнг нэгтгэх/ <i>20 минут</i>	15:32-15:52
Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах <i>Тооллогын комиссын дарга Н.Сайнзул</i>	15:52-15:55
Хурлаас гарах тогтоолын төсөлд Тооллогын комиссын санал хураалтын дүнг тусган танилцуулж, тогтоолыг батлуулах <i>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ</i>	15:55-15:57
Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хаах <i>Хурлын дарга Д.Гэрэлмаа</i>	15:57-16:00
Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг <i>Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.</i>	




## 1. ГОВЬ ХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮН

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, СЕГМЕНТЭЭР /тэрбум төгрөг, %/




БОРЛУУЛАЛТ. ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/






## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



2007 оны хувьчлалаас хойш өссөн дүнгээрээ нийт 176.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс 2019 онд 60.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 23.2 тэрбум нь Говь ХК-ийн барилга байгууламж, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгө оруулалтад зарцуулагдсан бол үлдсэн 37.3 тэрбум төгрөг нь Гоёо ХХК-г нэгтгэсний дүнд үүссэн өсөлт байв.

## 2024 оны хөрөнгө оруулалт




2024 онд нийт 20.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 49% буюу 9.9 тэрбум төгрөг нь тоног төхөөрөмж, 13% буюу 2.7 тэрбум төгрөг нь барилга байгууламж, 29% буюу 5.9 тэрбум төгрөг нь биет бус хөрөнгө, 9% буюу 1.8 тэрбум төгрөг нь тавилга эд хогшил болон бусад биет хөрөнгөд зарцуулсан байна.



## ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ, ШИМТГЭЛ


Говь ХК нь 2007 оноос хойш зөвхөн Монголын татварын албанд нийт 269.9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна. Үүнээс 2023 онд 33.7 тэрбум төгрөгийн татвар хураамж, шимтгэлийг улсын төсөвт төлсөн. Үүнийг нэр төрөл болон онуудаар дэлгэрүүлэн харуулав.




## 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2023 он	2024 он	Өөрчлөлт	
				тоо	хувь
<b>БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО</b>	сая.төг	255,651	<b>247,026</b>	(8,624)	-3%
Дотоод борлуулалт	сая.төг	146,997	<b>163,359</b>	16,362	11%
Экспортын борлуулалт	сая.төг	59,485	<b>57,934</b>	(1,550)	-3%
Гадаад борлуулалт	сая.төг	49,169	<b>25,733</b>	(23,436)	-48%
Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхэг	мян.ширхэг	1,153	<b>1,055</b>	(98)	-9%
<b>БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ</b>	сая.төг	131,011	<b>138,552</b>	7,541	6%
<b>НИЙТ АШИГ</b>	сая.төг	124,639	<b>108,474</b>	(16,165)	-13%
Бохир ашгийн хувь	хувь	49%	<b>44%</b>	-5%	-10%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	124,142	<b>109,504</b>	(14,639)	-12%
Маркетингийн зардал	сая.төг	27,803	<b>9,448</b>	(18,354)	-66%
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ</b>	сая.төг	497	<b>(1,030)</b>	(1,526)	-307%
Үйл ажиллагааны ашгийн хувь	хувь	0%	<b>0%</b>	-1%	-315%
Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	474	<b>544</b>	70	15%
Татварын өмнөх ашиг	сая.төг	23	<b>(1,574)</b>	(1,597)	-6905%
<b>ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ</b>	сая.төг	(6,768)	<b>(3,657)</b>	3,111	46%
Цэвэр ашгийн хувь	хувь	-3%	<b>-1%</b>	1%	44%
Нийт үйл ажиллагааны зардал	сая.төг	255,154	<b>248,056</b>	(7,098)	-3%
<b>ҮЙЛДВЭРЛЭЛ</b>	мян.ширхэг	1,040	<b>1,005</b>	(35)	-3%
Сүлжмэл бүтээгдэхүүн	мян.ширхэг	742	<b>653</b>	(89)	-12%
Нэхмэл бүтээгдэхүүн	мян.ширхэг	264	<b>323</b>	59	22%
Оёмол бүтээгдэхүүн	мян.ширхэг	34	<b>29</b>	(5)	-14%
Пальто	мян.ширхэг	18	<b>16</b>	(2)	-9%
Пиджак	мян.ширхэг	5	<b>5</b>	(0)	-2%
Ээрмэл утас	тонн	273	<b>191</b>	(82)	-30%
<b>АЖИЛТНУУДЫН ТОО</b>	хүн	1,765	<b>1,652</b>	(113)	-6%
Нэг ажилтанд ногдох орлого	мян.төг	144,844	<b>149,532</b>	4,687	3%
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	сая.төг	4,809	<b>20,354</b>	15,545	323%
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	сая.төг	311,950	<b>304,820</b>	(7,130)	-2%
Банкны зээл	сая.төг	237,319	<b>228,136</b>	(9,183)	-4%
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	сая.төг	311,784	<b>306,277</b>	(5,506)	-2%
Бараа материал	сая.төг	142,521	<b>122,708</b>	(19,813)	-14%

### БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО /тэрбум төгрөг/




### ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/




2024 онд 247 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан ба бүтцээр нь задалбал, сүлжмэл бүтээгдэхүүний борлуулалт 60%, нэхмэл болон оёмол бүтээгдэхүүн тус бүр 19%, бусад бүтээгдэхүүний борлуулалт 3%-ийг эзэлж байна. Компанийн 2024 оны цэвэр алдагдал 3.7 тэрбум төгрөг байсан ба өмнөх оноос 46%-аар алдагдлын хэмжээгээ бууруулсан үр дүнтэй байна. Тайлант үеийн алдагдал нь тайлант үеийн эцэс дэх өөрийн хөрөнгийн дүнгийн 30 хувиас хэтэрсэн байна.

### АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ




### ӨР ТӨЛБӨР/ЕБИТДА




2024 оны ашигт ажиллагааны гүйцэтгэлийг 2023 онтой харьцуулахад үйл ажиллагааны ашгийн хувь 1 пунктээр, ЕБИТДА хувь 2 пунктээр, цэвэр ашгийн хувь 2 пунктээр тус бүр сайжирсан. Мөн өр төлбөр/ЕБИТДА харьцаа сайжирч 5.7 болсон.

### НИЙТ ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/




### БАРАА МАТЕРИАЛЫН ЭРГЭЦ /хоног/




2024 онд түүхий эдийн татан авалтыг хамгийн бага түвшинд хийж, нөөцөө бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр бараа материалын эргэц хоног 2023 оноос 5%-р буурч 358 хоног болж сайжирсан.



### ҮЙЛДВЭРЛЭСЭН ТОО /мянган ширхэг/




### БОРЛУУЛСАН ТОО /мянган ширхэг/




2024 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо 3%, борлуулсан бүтээгдэхүүний тоо 9%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Нэхмэл бүтээгдэхүүний хувьд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний 32%-г эзэлж байгаа нь өмнөх оноос 7 пунктээр өссөн үзүүлэлт юм.

### МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ /тэрбум төгрөг/



2024 онд маркетингийн зардалд 9.4 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 66% буурсан үзүүлэлт байлаа. Нийт маркетингийн зардлын 83%-г гадаад зах зээлд зарцуулсан бөгөөд гадаад зах зээлийг идэвхжүүлэх маркетингийн зардлыг өмнөх оноос 70%-аар бууруулж 7.9 тэрбум төгрөгийг зарцуулсан. Гадаад зах зээлийн ROAS буюу 1 төгрөгийн маркетингийн зардлаас олж буй орлогын дүн 4.2 төгрөг болж сайжирсан. Охин компанийн ашигт ажиллагааг сайжруулах хүрээнд хямдралын хувийг 7.1 пунктээр бууруулсан.

### МӨНГӨН УРСГАЛ /тэрбум төгрөг/



2024 онд үйл ажиллагаанаас нийт 261.3 тэрбум төгрөг орсон ба 2023 онтой харьцуулахад 3% буурсан. Харин гарах мөнгөн урсгалын хувьд нийт 238.2 тэрбум төгрөг зарцуулсан ба үүнээс 92 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардалд, 82.6 тэрбум төгрөгийг бэлтгэн нийлүүлэгчдийн төлбөрт, 39.6 тэрбум төгрөгийг татварын зардалд, санхүүжилтийн зардалд 24.2 тэрбум төгрөг тус тус төлсөн. 2024 онд 16.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ -11.5 тэрбум төгрөг байна.

### САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

Санхүүжүүлэгчийн нэр	Валют	Дуусах хугацаа	2023.12.31		2024.12.31	
			мян. валют	мян.төг	мян.валют	мян.төг
<b>Банкны зээл</b>						
Голомт банк (Урт хугацаат зээл)	MNT	2025	-	13,333,333	-	3,333,333
Голомт банк (Зээлийн шугам)	MNT	2026	-	48,950,000	-	-
	USD	2026	-	-	-	-
Голомт банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	-	-	9,300,000
Голомт банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	-	-	10,400,000
Хаан банк (Зээлийн шугам)	MNT	2025	-	6,500,000	-	-
Хаан банк (Урт хугацаат зээл)	MNT	2024	-	4,202,775	-	-
Хаан банк (Богино хугацаат зээл)	MNT	2024	-	10,000,000	-	-
Хас банк (Зээлийн шугам)	MNT	2026	-	-	-	36,210,000
Хас банк (Богино хугацаат зээл)	MNT	2024	-	16,666,667	-	-
Хас банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	-	-	8,333,333
Ариг банк (Богино хугацаат зээл)	MNT	2024	-	14,500,000	-	-
Азийн хөгжлийн банк (ADB)	USD	2026	-	-	\$ 14,400	49,251,600
Азийн хөгжлийн банк (ADB)	USD	2026	\$12,000	40,928,280	\$ 9,600	32,834,400
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	2027	€ 8,000	30,333,280	€ 8,000	28,535,840
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	2027	€ 14,000	53,083,240	€ 14,000	49,937,720
<b>Нийт /Банкны зээл/</b>				<b>238,497,575</b>		<b>228,136,227</b>
<b>Бондын санхүүжилт</b>						
Бонд (Богино хугацаат зээл) *	USD	2025	-	-	\$ 3,250	11,115,813
<b>Нийт санхүүжилт</b>				<b>238,497,575</b>		<b>239,252,039</b>

Монгол банкны ханш /төг/

	2023.12.31	2024.12.31
USD	3,410.69	3,420.25
EUR	3,791.66	3,566.98

\* Говь ХК нь "Говь Бонд 2" санхүүжилт татах ажлын хүрээнд 2024 оны 4-р сарын 23-ны өдөр эрх бүхий байгууллагын тогтоолоор хаалттай хүрээнд эргэлтийн хөрөнгө, дахин санхүүжилт, хөрөнгө оруулалт хийх зорилгоор 12 сарын хугацаатай, жилийн 8.5%-ийн купонтой 16,800,000 ам.долларын бонд гаргах зөвшөөрөл авсан бөгөөд 2024 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 3,250,000 ам.долларын бондыг хөрөнгө оруулагчдаас татсан байна.





## ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй.

### СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Огноо	Гэрээ хэлцлийн утга	Үнийн дүн	Гэрээний нөгөө тал	Гэрээний нөхцөл, болзол	Эхлэх огноо	Дуусах огноо	Хэлцэл баталсан
2024.05.02	Хаан банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	Зээлийн эрхийн хэмжээг	Хаан Банк	Таван Богд Холдингс ХХК болон түүний охин компаниудтай хамтарсан зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	2024.05.12	2025.05.25	ТУЗ-ийн тогтоол №21
2024.12.31	Зээлийн эрх нээх гэрээ байгуулах	8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн	Хаан банк	Таван Богд Холдингс ХХК болон түүний охин компаниудтай хамтран зээлийн эрх нээх гэрээ байгуулах	2024.12.31	2027.12.31	ТУЗ-ийн тогтоол №41

#### Сонирхлын зөрчилтэй болон холбоотой талуудтай хийх хэлцэлд зөвшөөрөл олгох, хяналт тавих процесс

Говь ХК-ийн "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам"-ын дагуу жил бүрийн эхэнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах хэлцэл хийхийг зөвшөөрсөн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт, хэлцлийн төсвийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар баталдаг. Дээрх журмын дагуу батлагдсан жагсаалтад ороогүй этгээдтэй хийх болон батлагдсан төсвөөс хэтэрсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх бүрд тухайлсан тогтоолоор ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн зөвшөөрөл олгодог.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь Компанийн хэмжээнд хийгдэж буй сонирхлын зөрчилтэй хэлцэл нь батлагдсан төсвийн хүрээнд, зах зээлийн үнэ нөхцөлөөр, хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх дээр улирал бүрийн хорооны хурлаараа дамжуулан тогтмол хяналт тавьж ажилладаг.

2024 оны хувьд 2024 оны 1-р сарын 26-ны ТУЗ-ийн №03 тоот тогтоолоор холбоотой талуудын жагсаалт болон төсвийг баталж, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах зөвшөөрлийг олгосон.

Говь ХК-ийн нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдүүд болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг энэхүү тайлангийн 20-р хуудаснаас харж танилцах боломжтой.



## 2024 ОНЫ ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭ БА ҮЛДЭГДЭЛ /мянган төгрөг/

### 1. Холбоотой талуудын дансны үлдэгдэл

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудын үлдэгдэл дараах байдалтай байна:

	2023	2024
<b>Холбоотой талаас авах авлага</b>		
Бусад холбоотой талууд	129,632	<b>70,162</b>
<b>Холбоотой талд өгөх өглөг /Богино хугацаат/</b>		
Дээд шатны хянагч этгээд	13,642,760	<b>25,309,850</b>
Зэргэлдээ охин компаниуд	10,630,000	-
Бусад холбоотой талууд	703	-
<b>Холбоотой талд өгөх өглөг /Урт хугацаат/</b>		
Дээд шатны хянагч этгээд	17,032,986	-
<b>Холбоотой талаас авсан зээл</b>		
Бусад холбоотой талууд	20,475,228	-

Холбоотой талд өгөх урт хугацаат өглөг нь Таван Богд Холдингс ХХК-аас Гоёо ХХК-ийн хувьцааг зээлээр худалдан авсантай холбоотой. Тус гэрээнд аливаа хөрөнгийг барьцаалаагүй.

Холбоотой талуудын дансны үлдэгдэлд барьцаагүй ба найдваргүй авлагын сан байгуулаагүй.

### 2. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Дараах ажил гүйлгээг Группийн дээд шатны хянагч компани болох Таван Богд Холдингс ХХК-тай хийсэн байна:

	2023	2024
Дээд шатны хянагч компаниас авсан урьдчилгаа	200,750,000	<b>177,957,846</b>
Дээд шатны хянагч компаниас авсан урьдчилгааны төлбөр	200,750,000	<b>183,297,808</b>
Дээд шатны хянагч компанид өгсөн урьдчилгаа	18,950,000	-
Дээд шатны хянагч компанид өгсөн урьдчилгааны төлбөр	18,950,000	-
Дээд шатны хянагч компаниас авсан худалдан авалт	1,375,508	<b>1,379,271</b>
Дээд шатны хянагч компанид хийсэн борлуулалт	33,051	<b>22,792</b>
Дээд шатны хянагч компанид төлөх хүүгийн зардал	5,816,451	<b>4,378,356</b>
Дээд шатны хянагч компанид төлсөн хүүгийн зардал	5,816,451	<b>4,378,356</b>

Дараах ажил гүйлгээг Группийн нэгдсэн хяналтад байдаг бусад холбоотой талуудтай хийсэн байна:

	2023	2024
Бусад холбогдох этгээдээс авсан санхүүжилт	252,920,000	<b>325,232,000</b>
Бусад холбогдох этгээдээс авсан санхүүжилтийн эргэн төлөлт	242,290,000	<b>335,862,000</b>
Бусад холбоотой талуудаас авсан худалдан авалт	1,776,029	<b>1,715,066</b>
Бусад холбоотой талаас авсан худалдан авалт	25,932	-
Бусад холбоотой талд хийсэн борлуулалт	251,554	<b>174,981</b>
Бусад холбоотой талаас авсан түрээсийн орлого	292,062	<b>304,733</b>
Бусад холбоотой талд төлөх хүүгийн зардал	2,226,785	<b>2,575,220</b>
Бусад холбоотой талд төлсөн хүүгийн зардал	2,226,785	<b>2,575,220</b>




Дараах ажил гүйлгээг дээд шатны хянагч компанийн хараат компани болох ХААН банктай хийсэн байна:

	2023	2024
Хаан банкнаас авсан санхүүжилт	81,700,000	148,311,216
Хаан банкнаас авсан санхүүжилтийн эргэн төлөлт	70,997,225	169,011,431
Хаан банканд хийсэн борлуулалт	138,672	231,895
Хаан банкинд төлөх хүүгийн зардал	555,651	478,232
Хаан банкинд хүүгийн төлбөр төлөх	524,089	531,164

Бүх холбоотой талын гүйлгээ нь харилцан тохиролцсон нөхцөлөөр хийгдсэн.

### 3. ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ

• Санхүүжилтийн зардал	2023	2024
Нийт санхүүжилтийн зардал	31,150,837	30,117,480
Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардал	8,598,888	7,431,806
Эзлэх хувь /холбоотой тал/	28%	25%




Говь ХК нь 2024 онд холбоотой талын санхүүжилтийн зардалд 7,431,806 мянган төгрөг төлсөн нь нийт санхүүжилтийн зардлын 25%-ийг эзэлж байна. Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардлын дундаж төгрөгийн хүү нь 13.2%, ам.долларын 7.7% байна.


Жич: Холбоотой тал нь олгосон санхүүжилтэд санхүүгийн харьцаа болон барьцаа хөрөнгө шаарддаггүй.

• Худалдан авалт	2023	2024
Нийт худалдан авалт	102,285,245	94,696,681
Гадаадын худалдан авалт	22,143,070	34,037,838
Дотоодын худалдан авалт	80,142,175	60,658,842
Холбоотой талаас авсан худалдан авалт	3,040,428	2,960,699
Эзлэх хувь/нийт худалдан авалтад холбоотой талын эзлэх хувь/	3.0%	3.1%
Эзлэх хувь/дотоодын худалдан авалтад холбоотой талын эзлэх хувь/	3.8%	4.9%

#### НИЙТ ХУДАЛДАН АВАЛТ



#### ДОТООДЫН ХУДАЛДАН АВАЛТ




Говь ХК нь 2024 онд холбоотой талаас авсан худалдан авалтын дүн 2,960,699 мянган төгрөг буюу нийт худалдан авалтад эзлэх хувь 3.1% байна /2023 онд 3.0%/.

Холбоотой талаас авсан худалдан авалт нь зах зээлийн үнээр хийгдсэн.

Жич: Бүх холбоотой талын гүйлгээ нь Говь ХК-ийн "Худалдан авалтын бодлого", "Захиалга хүлээн авах, худалдан авах, хүлээлгэн өгөх журам", "Ажил үйлчилгээ худалдан авах журам", "Сонгон шалгаруулах хорооны журам"-ын дагуу үнийн харьцуулалт судалгааг хийн, сонгон шалгаруулалтын хороогоор орсны үндсэн дээр зах зээлийн үнээр хийгдсэн бөгөөд харилцан давуу байдлыг олгоогүй болно.



### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО  
**780,112,500**

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ТОО  
**25,151**

*/2024.12.31-ний байдлаар/*

### НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Хувьцаа эзэмшигчийн нэр	2023.12.31		2024.12.31	
	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь
Таван Богд Холдингс ХХК	400,140,072	51.29%	681,267,736	87.33%
Хиде Интер ХХК	265,238,300	34.00%	-	-

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч: Компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.

#### Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтцэд орсон гол өөрчлөлт

2024 оны 3-р сард нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт орж Таван Богд Холдингс ХХК нь Говь ХК-ийн 87.33%-ийг эзэмшдэг болсон.

Үүнтэй холбоотойгоор Компанийн тухай хууль (КТХ)-ийн 53.2-д заасны дагуу "Таван Богд Холдингс" ХХК-ийн хувьцааны эзэмшил 75 хувийг давсан тул Говь ХК-ийн бусад хувьцаа эзэмшигчид хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг КТХ-ийн 53 болон 54-р зүйлд заасны дагуу хуулийн хугацаанд хэрэгжүүлэх үүрэг Говь ХК-д үүссэн тул манай компани хуульд заасан үүргээ хэрэгжүүлэн, бусад хувьцаа эзэмшигчдийн эрхийг эдлүүлж, тэдний эрх ашгийг хангах зорилгоор "Бусад хувьцаа эзэмшигчдийн Хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх" шийдвэрийг гаргаж нэгж хувьцааг 268.26 төгрөгөөр эргүүлэн худалдаж авсан.

Тус шийдвэртэй холбоотой хувьцаа эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийг 2024 оны 4-р сарын 24-ний өдрөөс 2024 оны 6-р сарын 5-ны өдрийг дуустал цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авсан.

Дээрх хугацаанд нийт 96 хувьцаа эзэмшигчээс 3,427,017 ширхэг хувьцааг худалдах хүсэлт хүлээн авсан бөгөөд төлбөрийг 2024 оны 06-р сарын 12-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн дансанд нь байршуулсан болно. Шаардах эрхийг хуулийн дагуу хэрэгжүүлсэн тухай тайланг бэлтгэн 2024 оны 6-р сарын 13-ны өдөр СЗХ, МХБ-д хүргэсэн.


## НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Компанийн нэрс	Д/д	Компанийн нэрс
1	Таван Богд Холдингс ХХК	21	Таван Богд Билдинг Саглай ХХК
2	Таван Богд Интернэйшнл ХХК	22	Таван Богд Тэтгэврийн Хуримтлал ХХК
3	Таван Богд Дистрибьюшн ХХК	23	Таван Богд Моторс ХХК
4	Таван Богд ХХК	24	Гэрлүг Виста Сервис ХХК
5	Эйрлинк Монголиа ХХК	25	Таван Богд Нура ХХК
6	Улаанбаатар Гурил ХХК	26	Ти Би Эм Өү ХХК
7	Жуулчин ХХК	27	Таван Богд Автомотив ХХК
8	Жуулчин Дюти Фрий ХХК	28	Таван Богд Дилер ХХК
9	Файв Старс Ин Хархорин ХХК	29	Жуулчин Фүүдс ХХК
10	Хаан Палас ХХК	30	Горхийн Чулуу ХХК
11	Сэргэлэн Резорт ХХК	31	Говийн Од Групп ХХК
12	Таван Богд Фүүдс ХХК	32	Таванбогд Констракшн Машинери ХХК
13	Таван Богд Фүүдс Пицца ХХК	33	Таван Богд Ассет Менежмент ХХК
14	Улаанбаатар Принт ХХК	34	Juulchin World Gmbh /ХБНГУ/
15	Таван Богд Фүүд Сервис ХХК	35	Саппортсервисес Монголиа ХХК
16	Таван Богд Проперти ХХК	36	Хаан Банк ХК
17	Таван Богд Хаус ХХК	37	Тэмүүжин цогцолбор ХХК
18	Таван Богд Резиденс ХХК	38	Жуулчин Туризм Корпорэйшн ХХК
19	Таван Богд Финанс ББСБ ХХК	39	Ар И Ди Эженси ХХК
20	Таван Богд Капитал ҮЦК ХХК	40	Вайт Маркетинг Эйженси ХХК


## ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Овог, нэр	Иргэний харьяалал	Эзэмшлийн хувь	
			Хувь хүн	Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд
1	Цагаач БААТАРСАЙХАН	Монгол	0.006%	Таван Богд Холдингс ХХК 87.33% Таван Богд ХХК 0.40% Таван Богд Капитал ҮЦК ХХК 0.04%

## ДОТООД ЗАХ ЗЭЭЛ



## БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР ТӨРӨЛ /мянган ширхэг/



Борлуулсан бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нь задалбал, сүлжмэл бүтээгдэхүүн 58%, оёмол бүтээгдэхүүн 4%, нэхмэл бүтээгдэхүүн 35%, бусад бүтээгдэхүүн 3%-ийг тус тус эзэлж байна.

2024 онд дотоодын зах зээлд ноолууран гутлыг олон нэр төрлийн сонголттойгоор хүргэхээс гадна, цүнх, куртка, савхин бээлий гэх мэт олон шинэлэг бүтээгдэхүүнийг борлуулж эхэлснээр outsourcing буюу гадаадад гэрээт үйлдвэрлэгчтэй хамтран үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалт 686%-ийн өсөлтийг үзүүлсэн үр дүнтэй байлаа.



## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



Хими цэвэрлэгээ, нөхөн засвар хүлээн авах шинэ салбарыг И-Мартын Хан-Уул салбар дотор нээв.



VIP хэрэглэгчид, хувьцаа эзэмшигчид болон аялал жуулчлалын компаниудын оролцогч талууддаа намар, өвлийн 2024 коллекцийг танилцуулах арга хэмжээг зохион байгуулав.



Аялал жуулчлалын улирлын нээлтийн арга хэмжээг зохион байгуулж хөтөч, жолооч, аяллын компаниудын төлөөлөл бүхий 217 зочинд жуулчны улирлын үеэр хамтран ажиллах төлөвлөгөөгөө танилцуулж мэдээлэл хүргэн хамтын ажиллагааг эхлүүлэв.



Flagship Store буюу төв дэлгүүрийн үндсэн тасгийн засвар, шинэчлэлийг хийн, албан ёсны нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, хүрэлцэн ирсэн зочид үйлдвэрээр аялан бүтээгдэхүүн бий болох үйл явцтай танилцав.




BARÇA-ийн албан ёсны мерчендайзинг эрхийн гэрээ байгуулах хэлэлцээр амжилттай үргэлжилж, ерөнхийлөгч Жоан Лапортаг Галлериа салбар дэлгүүрт хүлээн авлаа.




Нисэх салбар дэлгүүрийн сонгон шалгаруулалтад шалгарч дэлгүүр нээх эрхээ авсан ба 2025 оны 1-р улиралд нээхээр бэлтгэл ханган ажиллаж байна.



## ГАДААД ЗАХ ЗЭЭЛ




2024 онд гадаад зах зээлд нийт 83.7 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан ба энэ нь өмнөх оноос 23% буурсан үзүүлэлт байв.




Гадаад зах зээлийг бүтцээр нь аваад үзвэл 69%-ийг экспортын буюу бөөний борлуулалт, 31%-ийг гадаад дахь охин компанийн борлуулалт буюу онлайн болон биет дэлгүүрийн борлуулалт эзэлж байна.

## ЭКСПОРТЫН БОРЛУУЛАЛТ



Экспортын борлуулалтын хувьд манай компани цөөн, чанартай стратегийн харилцагчидтай хамтран ажиллах бодлогыг баримталж байгаа бөгөөд 2024 онд 50 харилцагчид бүтээгдэхүүнээ нийлүүлж, 57.9 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан.



2024 оны сүүлийн байдлаар 3 улсын 7 хотод 8 франчайз дэлгүүртэй үйл ажиллагаа явуулж байна.





## ГАДААД БОРЛУУЛАЛТ



### ВЕБСАЙТ

- EU**
- www.gobicashmere.com
  - www.gobicashmere.com/DE
  - www.gobicashmere.com/FR
- UK**
- www.gobicashmere.com/UK
- US**
- www.gobicashmere.com/US
- CN**
- www.gobicashmere.cn

### ПЛАТФОРМ

- EU**
- Zalando: DE, AUT, FR, SWE
  - Nordstorm: US
  - OTTO: DE
- CN**
- TMALL, JD

### САЛБАР ДЭЛГҮҮР

- Germany**
- Berlin
  - Düsseldorf

Гадаад борлуулалтын суваг хөгжүүлэх ажлын хүрээнд 2024 оны сүүлээр Европын Холбоо болон Америкийн Нэгдсэн Улсын зах зээлд хоёр шинэ борлуулалтын сувагтай хамтран ажиллаж эхэллээ.

АНУ-д алдартай дээд зэрэглэлийн цахим дэлгүүр болох Nordstrom-д 2024 оны 10-р сард нэгдэж зорилтот үйлчлүүлэгчдэд нэг алхам ойртож чадлаа. Мөн Германд цахим худалдааны зах зээлд чансаагаараа хоёрт ордог OTTO-д 2024 оны 12-р сараас бүтээгдэхүүнээ байршуулан борлуулалт хийж эхэллээ. Борлуулалтын оргил үед тус сувгуудтай хамтран ажиллаж эхэлсэн нь 2024 оны нийт борлуулалтын үр дүнд эерэг нөлөө үзүүлсэн байна.

Түүнчлэн 2024 оны 11-р сард туршилтын 4 сарын хугацаатай гэрээ хийн АНУ-ын New York хотын алдарт Roosevelt Field Mall худалдааны төвд манай Pop-up дэлгүүрийг нээн ажилласан нь богино хугацаанд зорилтот хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ танилцуулж чадсан хэрэг байлаа.



## Борлуулалт

Борлуулалтын суваг	Борлуулалт /сая төгрөг/		Өөрчлөлт %	Борлуулалтад эзлэх %
	2023	2024		
Вебсайт	43,621	18,047	-59%	70%
Салбар дэлгүүр	3,894	4,112	6%	16%
Платформ	1,654	3,575	116%	14%
<b>НИЙТ</b>	<b>49,169</b>	<b>25,733</b>	<b>-48%</b>	<b>100%</b>

Гадаад борлуулалтыг сувгаар нь задлаад үзвэл вебсайтаар хийсэн онлайн борлуулалт 18.0 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 59% бууралттай, Герман улс дахь хоёр салбар дэлгүүрийн борлуулалт 4.2 тэрбум төгрөг буюу 6% өсөлттэй байсан бол худалдааны платформууд буюу Zalando, Nordstrom, OTTO-ийн онлайн борлуулалт 3.6 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 116% өсөлттэй байв.

## Голлох үзүүлэлтүүд

Зах зээл	CTR			CR			CPA		
	2023	2024	Өөрчлөлт %	2023	2024	Өөрчлөлт %	2023	2024	Өөрчлөлт %
Европ, Хойд Америк, Их Британи	43,621	18,047	+46%	2.24%	1.58%	-29%	\$65.15	\$48.41	-26%
Хятад	3,894	4,112	+23%	0.70%	0.72%	+3%	¥185.10	¥109.40	-41%

### Үзүүлэлтүүдийн тайлбар

**CTR /click through rate/**  
- Нийт сурталчилгаа харсан тооноос хэдэн хувь нь click буюу үйлдэл хийснийг илэрхийлэх хувь

### CR /conversion rate/

- Нийт веб рүү зочилсон зочлолтын хэдэн хувь нь худалдан авалт хийж буйг илэрхийлэх хувь

### CPA /cost per acquisition/

- Нэг захиалга хийлгэхэд гаргаж буй дижитал маркетингийн зардал

## Онцлох үйл явдлууд



### NPDI x GOBI хамтын ажиллагаа

Гадаад борлуулалтын зах зээлд 2023 оноос хойш SEO буюу Search Engine Optimization компаниудтай хамтран ажиллаж брэндийн органик хайлтыг сайжруулах зорилгоор үе шаттай арга хэмжээг аван ажиллаж байгаа бөгөөд 2024 оноос эхлэн NPDI Agency-тэй хамтын ажиллагааг эхлүүлж, шинэ түлхүүр үгсийн судалгааг хамтран хийж, GOB-ийн брэндийн органик хандалтыг өсгөхөд анхаарч ажилласан.

### NORDSTROM



OTTO

### Борлуулалтын суваг хөгжүүлэлт

- 2024 оны 10-р сард АНУ-ын 120 жилийн баялаг түүхтэй, 365 салбар дэлгүүр болон онлайн худалдаагаар алдартай "Nordstrom" худалдааны онлайн платформуор бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн.
- 2024 оны 11-р сард АНУ-ын Нью Йорк хот дахь алдарт Roosevelt Field Mall худалдааны төвд Mongolian Gallery-ийн хамт олонтой хамтран Поп-Ап дэлгүүр нээсэн.
- 2024 оны 12-р сараас Германы онлайн худалдааны өсөлтийг дэмжих зорилгоор тус улсын тэргүүлэгч худалдааны онлайн платформуудын нэг болох OTTO-д нэгдэж бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд хүргэж эхэлсэн.



## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(мянган төгрөг)

	2023 (Дахин тайлагнасан)	2024
<b>Хөрөнгө</b>		
<i>Эргэлтийн хөрөнгө</i>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	9,491,111	4,326,046
Урьдчилгаа төлбөр	3,173,680	3,512,304
Дансны болон бусад авлага	8,030,908	9,404,878
Бараа материал	142,521,277	122,708,175
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө	-	-
	<b>163,216,976</b>	<b>139,951,403</b>
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>		
Үндсэн хөрөнгө	111,731,120	146,412,229
Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	2,109,746	2,780,438
Хойшлогдсон татварын хөрөнгө	9,276,559	5,661,214
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	7,930,958	11,472,217
	<b>131,048,383</b>	<b>166,326,098</b>
<b>Нийт хөрөнгө</b>	<b>294,265,359</b>	<b>306,277,501</b>
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>		
<i>Богино хугацаат өр төлбөр</i>		
Дансны болон бусад өглөг	38,880,126	37,867,812
Гэрээний өр төлбөр	1,672,424	2,129,778
Буцаах эрхтэй барааны өр төлбөр	-	-
Богино хугацаат түрээсийн өглөг	964,376	1,103,295
Орлогын албан татварын өглөг	1,801,506	381,026
Богино хугацаат зээл	232,559,514	211,265,887
	<b>275,877,946</b>	<b>252,747,798</b>
<i>Урт хугацаат өр төлбөр</i>		
Урт хугацаат түрээсийн өглөг	1,321,948	1,922,734
Урт хугацаат зээл	9,830,059	36,210,000
Бусад урт хугацаат өглөг	17,036,260	-
Хойшлогдсон татварын өглөг	7,883,775	13,939,844
	<b>36,072,042</b>	<b>52,072,578</b>
<b>Нийт өр төлбөр</b>	<b>311,949,988</b>	<b>304,820,376</b>
<i>Эздийн өмч</i>		
Хувьцаат капитал	780,113	780,113
Дахин үнэлгээний нөөц	20,514,269	43,777,386
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(10,662,273)	(12,119,789)
Хуримтлагдсан алдагдал	(28,316,738)	(30,980,585)
	<b>(17,684,629)</b>	<b>1,457,125</b>
<b>Нийт эздийн өмч</b>	<b>(17,684,629)</b>	<b>1,457,125</b>
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>294,265,359</b>	<b>306,277,501</b>



## НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

(мянган төгрөг)

	2023	2024
Борлуулалтын орлого	255,650,516	247,026,317
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(131,011,345)	(138,552,341)
<b>Нийт ашиг</b>	<b>124,639,171</b>	<b>108,473,976</b>
Бусад орлого	6,525,518	3,649,691
Борлуулалт ба маркетингийн зардал	(73,593,361)	(53,217,129)
Ерөнхий ба удирдлагын зардал	(19,733,240)	(24,908,151)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт	9,266	-
Бусад зардал	(6,980)	(6,919,419)
<b>Үйл ажиллагааны ашиг</b>	<b>37,840,374</b>	<b>27,078,968</b>
Санхүүгийн орлого	229,734	4,465,583
Санхүүгийн зардал	(38,046,985)	(33,118,100)
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>23,123</b>	<b>(1,573,549)</b>
Орлогын албан татварын зардал	(6,791,081)	(2,083,660)
<b>Тайлант жилийн цэвэр алдагдал</b>	<b>(6,767,958)</b>	<b>(3,657,209)</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого:</b>		
<b>Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:</b>		
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөлөө	-	32,341,972
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний татварын нөлөө	-	(8,085,493)
<b>Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжгүй бусад дэлгэрэнгүй орлого:</b>		
Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	773,737	(1,457,516)
<b>Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>773,737</b>	<b>22,798,963</b>
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал</b>	<b>(5,994,221)</b>	<b>19,141,754</b>



## НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(мянган төгрөг)

	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан алдагдал	Нийт
<b>2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл</b>	<b>780,113</b>	<b>44,568,540</b>	<b>(11,436,010)</b>	<b>(28,084,878)</b>	<b>5,827,765</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө	-	(23,060,909)	-	5,542,736	(17,518,173)
<b>2023 оны 01 сарын 01-ний дахин тайлагнасан үлдэгдэл</b>	<b>780,113</b>	<b>21,507,631</b>	<b>(11,436,010)</b>	<b>(22,542,142)</b>	<b>(11,690,408)</b>
<i>Нийт дэлгэрэнгүй орлого:</i>					
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(6,767,958)	(6,767,958)
Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	-	773,737	-	773,737
<i>Эздийн өмчтэй холбоотой өөрчлөлт:</i>					
Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн	-ц	(993,362)	-	993,362	-
<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>780,113</b>	<b>20,514,269</b>	<b>(10,662,273)</b>	<b>(28,316,738)</b>	<b>(17,684,629)</b>
<b>2024 оны 01 сарын 01-ний үлдэгдэл</b>	<b>780,113</b>	<b>20,514,269</b>	<b>(10,662,273)</b>	<b>(28,316,738)</b>	<b>(17,684,629)</b>
<i>Нийт дэлгэрэнгүй орлого:</i>					
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(3,657,209)	(3,657,209)
Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	24,256,479	(1,457,516)	-	22,798,963
<i>Эздийн өмчтэй холбоотой өөрчлөлт:</i>					
Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн	(993,362)	-	993,362	-	-
<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>780,113</b>	<b>43,777,386</b>	<b>(12,119,789)</b>	<b>(30,980,585)</b>	<b>1,457,125</b>



## НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2023	2024
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Тайлант жилийн цэвэр алдагдал</b>	(6,767,958)	(3,657,209)
Тохируулгууд:		
Эргэлтийн бус хөрөнгийн элэгдэл ба хорогдлын зардал	12,643,029	14,554,268
Орлогын албан татварын зардал (өгөөж)	6,791,081	2,083,660
Хүүгийн зардал	30,257,198	28,966,791
Хүүгийн орлого	(229,734)	(21,032)
Хөнгөлөлттэй зээлийн дискаунтын нөлөө	4,418,776	3,000,620
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,176,462	1,103,637
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт	(9,266)	-
Бараа материалын хасагдуулгын зардал (буцаалт), цэвэр	(166,906)	197,117
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	6,980	60,004
	<b>48,119,662</b>	<b>46,287,856</b>
Өөрчлөлт:		
Дансны болон бусад авлага	(3,548,120)	(6,518,867)
Урьдчилгаа төлбөр	(6,148,480)	1,358,657
Бараа материал	(13,562,908)	19,615,985
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө	17,227	-
Дансны ба бусад өглөг	(11,962,418)	(5,048,402)
Буцаах эрхтэй барааны өр төлбөр	(26,503)	-
Гэрээний өр төлбөр	(311,474)	457,354
	<b>12,576,986</b>	<b>56,152,583</b>
Төлсөн орлогын албан татвар	(3,392,836)	(1,918,219)
Төлсөн хүү	(27,329,645)	(24,506,337)
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(18,145,495)</b>	<b>29,728,027</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Хүлээн авсан хүү	229,734	21,032
Үндсэн хөрөнгө борлуулснаас орж ирсэн мөнгө	1,359,228	25,055
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(4,642,753)	(15,206,659)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	(1,249,934)	(5,889,178)
	<b>(4,303,725)</b>	<b>(21,049,750)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Авсан зээл (холбоотой талыг оролцуулаад)	1,153,263,480	1,248,559,876
Гаргасан бонд	-	10,982,346
Төлсөн зээл (холбоотой талын зээлийг оролцуулаад)	(1,130,151,838)	(1,270,804,301)
Холбогдох талуудад өгсөн урьдчилгаа	(18,950,000)	-
Холбоотой этгээдэд олгосон урьдчилгаа төлбөр	18,950,000	-
Төлсөн түрээсийн төлбөр	(965,391)	(1,098,962)
Төлсөн ногдол ашиг	(280)	(355)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>22,145,971</b>	<b>(12,361,396)</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт) / өсөлт</b>	<b>(303,249)</b>	<b>(3,683,119)</b>
Гадаад валютын ханшийн зөрүү	773,737	(1,457,516)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл дэх ханшийн зөрүүний нөлөөлөл	(14,296)	(24,430)
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>9,034,919</b>	<b>9,491,111</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>9,491,111</b>	<b>4,326,046</b>

## 2.НОГДОЛ АШИГ

Манай компани нь дотоодын зах зээлд байр сууриа хадгалах, улмаар зах зээлд эзлэх хувиа өсгөх, гадаад болон онлайн худалдааны зах зээлээ тэлэхийн тулд техник, технологио шинэчлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр чармайн ажиллахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгө оруулалтын өгөөжийг тасралтгүй өсгөж, ногдол ашиг тогтмол тараах бодлогыг баримталдаг.

"Ногдол ашгийн журам"-ын 2-р бүлэгт ногдол ашгийн бодлогыг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

### НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

- Компанийн ногдол ашгийн бодлого нь Компанийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдан байна.
- Компани хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд байлгах бодлоготой ажиллана.
- Компани нь Компанийн тухай хуулийн 47-р зүйл, Компанийн дүрмийн 8.12-д заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна.
- Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тухайн санхүүгийн жилийн татварын дараах цэвэр ашгийн хэмжээ, Компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн ТУЗ тогтооно.
- Тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд ногдол ашгийн хэмжээг бууруулахгүй байх бодлого баримтална.
- Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгоно.
- Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.

### НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

Ногдол ашиг зарласан он	Хувьцааны тоо (ширхэг)	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төгрөг)	Нийт зарласан ногдол ашгийн дүн (төгрөг)	Ногдол ашиг тараалт
1997	7,801,125	153.80	1,199,813,025	
1998	7,801,125	150.00	1,170,168,750	
1999	7,801,125	166.00	1,294,986,750	
2000	7,801,125	100.00	780,112,500	2007 он хүртэлх ногдол ашгийг Говь ХК-ийн албан ёсны веб хуудсаар дамжуулан ирүүлсэн ногдол ашгийн хүсэлтийн дагуу шилжүүлж байна.
2001	7,801,125	20.16	157,270,680	
2002-2004	7,801,125	-	-	
2005	7,801,125	60.00	468,067,500	
2006	7,801,125	60.00	468,067,500	
2007-2009	7,801,125	-	-	Санхүүгийн үр дүнгээс шалтгаалан ногдол ашиг хуваарилаагүй.
2010	7,801,125	100.00	780,112,500	
2011	7,801,125	100.00	780,112,500	
2012	7,801,125	125.00	975,140,625	
2013	7,801,125	130.00	1,014,146,250	
2014	7,801,125	140.00	1,092,157,500	2010-2018 он хүртэлх ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн харилцдаг үнэт цаасны компаниуд руу 100% тараасан.
2015	7,801,125	140.00	1,092,157,500	
2016	7,801,125	200.00	1,560,225,000	
2017	7,801,125	220.00	1,716,247,500	
2018	780,112,500	6.80	5,304,765,000	
2019-2024	780,112,500	-	-	Санхүүгийн үр дүнгээс шалтгаалан ногдол ашиг хуваарилаагүй.

## 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮНГЭЭС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХГҮЙ ТУХАЙ

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2-р сарын 7-ны өдрийн №3 тоот тогтоолын дагуу 2024 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

GOBI



"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 он 02 сар 07 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

### Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Говь ХК-ийн 2024 оны санхүүгийн үр дүнг харгалзан, Компанийн тухай хуулийн 46.5, 46.6, 47.1 дүгээр заалт болон Компанийн дүрмийн 8.9, 8.12 дэх заалт, Ногдол ашгийн журмын 3.1 дүгээр заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

- Говь ХК нь 2024 оны санхүүгийн үр дүнд компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
- Говь ХК-ийн ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр тайлагнахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д даалгасугай.
- Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг зохих журмын дагуу эрх бүхий байгууллага болон олон нийтэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

Ц.БААТАРСАЙХАН

Б.АМАРСАЙХАН

Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Н.МӨНХБАТ

Ц.ОРГИЛБОЛД

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ

"Говь" ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17062, Монгол улс  
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, И-мэйл: info@gobi.mn, Вэб сайт: www.gobi.mn





## 3.ГОВЬ ХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ӨГӨХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ



Монгол Улсын Компанийн тухай хууль болон Говь ХК-ийн дүрмийн хүрээнд тус компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд өгөх дүгнэлтийг 2025 оны 3-р сарын 20-ны Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн хурлаар хэлэлцэж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

ТУЗ нь компанийн 2024 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилтуудыг баталж, хэрэгжилтийн явцад тогтмол хяналт тавьж, Гүйцэтгэх удирдлагын багийг шаардлагатай санал зөвлөмж, үүрэг даалгавраар ханган чиглүүлж ажилласан. Гүйцэтгэх удирдлагын баг нь батлагдсан төлөвлөгөө, зорилт, шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхийн төлөө хүчин чармайлт, тууштай хичээл зүтгэл гаргасныг ТУЗ-ийн зүгээс онцлон тэмдэглэж байна.

**ТУЗ-ийн баталсан 2024 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилт нь** компанийн борлуулалтын орлогыг өмнөх жилтэй ижил түвшинд барьж ашигт ажиллагааг сайжруулах, брэндийн цогц шинэчлэлтийг хийх, Төв дэлгүүрийн өнгө төрхийг иж бүрэн шинэчлэх, POS шинэ системийг нэвтрүүлэн урамшууллын системийг ашиглах, нөөцийн удирдлагыг сайжруулах, программ хангамж болон удирдлагын системүүдийг дараагийн түвшинд хөгжүүлэн ашиглаж эхлэх, бэлчээрийн доройтлын эсрэг төслийг өргөжүүлэх, хүний нөөцийн тогтворжилтыг хангаж байгууллагын соёлыг сайжруулах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, Говь академи байгуулах, залгамж халааг бэлтгэх замаар ур чадварыг системтэй хөгжүүлэх, бүтээгдэхүүний загвар дизайныг хөгжүүлж, нэр төрлийг нэмэгдүүлэх, бэлэн бүтээгдэхүүнд ОЕКО TEX-100 гэрчилгээ авах зэрэгт тус тус чиглэсэн билээ.

**Санхүүгийн үр дүнгийн хувьд**, өнгөрөгч 2024 онд 247.0 тэрбум төгрөгийн борлуулалт хийж бизнес төлөвлөгөөний биелэлт 98% байлаа. Дотоод борлуулалт 163.4 тэрбум төгрөг буюу төлөвлөгөөний биелэлт 103%, гадаад борлуулалт 25.7 тэрбум төгрөг буюу төлөвлөгөөний биелэлт 93%, экспортын борлуулалт 57.9 тэрбум төгрөг буюу төлөвлөгөөний биелэлт 88% байв. 2024 онд өмнөх онтой харьцуулахад алдагдлын хэмжээг 46% бууруулж 3.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд ашигт ажиллагааны гүйцэтгэлийг 2023 онтой харьцуулахад үйл ажиллагааны ашгийн хувь 1 пунктээр, EBITDA хувь 2 пунктээр, цэвэр ашгийн хувь 2 пунктээр тус бүр сайжирсан. Мөн өр төлбөр/EBITDA харьцаа сайжирч 5.7 болсон. Түүнчлэн түүхий эдийн татан авалтыг хамгийн бага түвшинд хийж, нөөцөө бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр бараа материалын эргэц хоног 2023 оноос 5%-аар буурч 358 хоног болж сайжирсан байна.

2024 онд маркетингийн зардлыг 66%-аар бууруулж, нийт 9.4 тэрбум төгрөгийг зарцуулсан. Гадаад зах зээлийн маркетингийн зардлыг өмнөх оноос 70%-аар бууруулж 7.9 тэрбум төгрөгийг зарцуулсан нь нийт маркетингийн зардлын 83%-ийг эзэлж байна. Охин компанийн ашигт ажиллагааг сайжруулах хүрээнд хямдралын хувийг 7.1 пунктээр бууруулсан ба гадаад зах зээлийн ROAS буюу 1 төгрөгийн маркетингийн зардлаас олж буй орлогын дүн 4.2 төгрөг болж сайжирсан.

**Үйлдвэрлэл ба бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хувьд**, 2024 онд 1 сая бүтээгдэхүүн үйлдвэрлэж төлөвлөгөөний биелэлт 106%, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлт 93% болж өмнөх оноос 1% өссөн. Мөн 1 сая ширхэг бүтээгдэхүүн борлуулж төлөвлөгөөний биелэлт 97% байв. Өнгөрөгч онд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн өнгөрөгч онд бүтээгдэхүүний нэр төрлийг өргөжүүлж, ноолууран гутлын олон төрлийн шинэ загваруудаас гадна саравчтай малгай, цүнх, CashmereTECH дэвшилтэт технологийн ноолууран дүүргэлттэй куртка, ноолууран дотортой савхин бээлий, лаа гэх мэт шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлж, ноолуурын хэрэглээний цар хүрээг зогсолтгүй өргөжүүллээ. Түүнчлэн, олон улсын "ОЕКО-TEX STANDARD 100" гэрчилгээг Монголд анх удаа бэлэн бүтээгдэхүүн дээр гардан авав.

Мөн Ерөнхий дизайнераар Италийн алдарт дизайнер Giorgio Spina үргэлжлүүлэн ажиллан Тогтвортой ноолуур 3 талт төслийн хүрээнд CashmeReborn, Responsible Cashmere коллекц, GOBI ба GOBI Organic FW24/25, SS25, FW25/26 зэрэг ноолууран бүтээгдэхүүний загварыг шинэ түвшинд хүргэсэн коллекцуудыг танилцуулав.

**Борлуулалтын зах зээлүүдийн хувьд**, дотоод борлуулалтыг дэмжих зорилгоор үнэнч хэрэглэгчдэд зориулсан урамшууллын хөтөлбөрийг нэвтрүүлж, Flagship Store буюу үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүрийг Монгол нутгийн онцлогийг шингээсэн орчин үеийн хэв маягтайгаар өнгө төрхийг бүрэн шинэчилж, хэрэглэгчдэд илүү ая тухтай үйлчилгээний орчин бүрдүүлсэн. Мөн гадаад зах зээлд 2024 онд маркетингийн стратегиа өөрчлөн, органик өсөлт, брэндийн үнэлэмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн маркетинг хийж, ашигт ажиллагааг сайжруулахад төвлөрч ажилласан.

**Компанийн программ хангамж болон удирдлагын системийн хувьд**, бизнесийн үйл ажиллагааг автоматжуулж, ажлын гүйцэтгэлийг хурдасгах, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор системийн шинэчлэлтийг дараагийн түвшинд гаргаж, нийт компанийн хэмжээнд SAP S/4 HANA Enterprise Resource Management (ERP) систем, RFID системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн. Мөн Монгол Улсын хөнгөн аж үйлдвэрийн салбарын түүхэнд анх удаа үйлдвэрлэл гүйцэтгэлийн систем (Manufacturing Execution System) болон дамжлагын систем (Conveyor Belt)-ийг нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн ба эдгээр системүүд нь үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, процессыг сайжруулах, санхүүгийн удирдлага, шийдвэр гаргалтыг оновчтой бөгөөд хурдан хийх боломжийг бүрдүүлэх юм.

**Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор**, тогтвортой хөгжлийн цогц бодлогыг боловсруулж эхлэн, мэргэжлийн хараат бус зөвлөх компанитай хамтран ТУЗ болон менежмент багийн түвшинд шат дараалсан сургалт, уулзалтуудыг зохион байгуулж Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого боловсруулж, уур амьсгалын өөрчлөлт, хүний эрх, жендерийн тэгш байдал, нийгмийн хариуцлагын чиглэлээр бодлогуудаа тодорхойлон баталсан. Мөн "Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл"-ийн үндсэн үйл ажиллагаанд тулгуурлан Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр уур амьсгалын өөрчлөлтөд малчдыг бүлгэмээр дасан зохицуулах, бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох туршилтын төслийг хэрэгжүүлж эхлэв.

**Хүний нөөцийн тогтворжилтыг хангаж байгууллагын соёлыг сайжруулах зорилгоор**, ажилтнуудын хүүхдүүдийн "Говийн багачууд цэцэрлэг" 3 дахь жилдээ амжилттай ажилласан ба Говь академийг байгуулж давтагдсан тоогоор 2,000 орчим ажилтанд дотоод сургалт орсон байна. Мөн ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах ажлуудыг шат дараатай хэрэгжүүллээ.

**Өнгөрөгч онд хэрэгжүүлсэн онцлох ажлуудаас дурдвал**, Говь ХК-ийг дэлхийн зах зээлд илүү өргөн хүрээнд таниулж, олон улсын түвшинд өрсөлдөхүйц компани болох зорилгоор Rebranding буюу брэндийн цогц шинэчлэлтийг хийснээр GOVЬ брэнд анх удаа бэлгэ тэмдэгтэй болж, шинэчилсэн лого ба шинэ өнгө төрхтэйгөөр дотоод болон гадаадын зах зээлд бүтээгдэхүүнээ хүргэж байна. Мөн хүний нөөцийн салбарын чуулган болох Mongolian Labor Market Summit: Good Workplace Awards 2024 арга хэмжээний үеэр "Эмэгтэйчүүдийн карьерын өсөлтийг дэмжигч шилдэг ажил олгогч"-оор шалгарсан нь 70 гаруй хувь нь эмэгтэй ажилтнуудаас бүрддэг манай компанийн хувьд ажилтнуудынхаа хөгжлийг дэмжих, тэгш боломжийг хангах бодлогын хэрэгжилтийг улам бүр бататгасан үнэ цэнтэй шагнал боллоо.

Дээр дурдсан үр дүнд үндэслэн Говь ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын баг нь 2024 онд шинэ удирдлагатайгаар төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглаж, компанийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангахын төлөө оновчтой бодлого хэрэгжүүлэн ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

## 4.КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТӨСӨЛ

№	Одоогийн дүрмийн заалт	Шинэчилсэн заалт	Тайлбар
1	-	<b>Арван нэг. Ахмадын сангийн тухай</b> <b>11.1 Компани нь ажиллаж байсан ахмад настанд Ахмад настны тухай хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ахмадын сан” байгуулан ажиллуулна.</b> <b>11.2 Ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн хэмжээг гүйцэтгэх удирдлага нь 2 жилд нэг удаа Үйлдвэрчний эвлэл болон түүний дэргэдэх Ахмадын хороотой хэлэлцэн тогтооно.</b>	Компанийн тухай хуулийн 2024.06.05-ны нэмэлт өөрчлөлтийн дагуу шинээр нэмж оруулав.
2	<b>Арван нэг.</b> Дүрмийн нэмэлт, өөрчлөлт. <b>11.1</b> Компанийн ТУЗ нь шаардлагатай тохиолдолд энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг хийх бол энэ талаар санал боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулна. <b>11.2</b> Энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.	<b>Арван хоёр.</b> Дүрмийн нэмэлт, өөрчлөлт. <b>12.1</b> Компанийн ТУЗ нь шаардлагатай тохиолдолд энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг хийх бол энэ талаар санал боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулна. <b>12.2</b> Энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.	Дугаарлалт өөрчлөгдөв.
3	5.1 Компани <b>гаргасан энгийн хувьцааг заавал гаргах</b> ба үүнээс гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаасыг нээлттэй ба хаалттай хэлбэрээр гаргаж болно.	5.1 Компани <b>энгийн хувьцааг заавал гаргах</b> ба үүнээс гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаасыг нээлттэй ба хаалттай хэлбэрээр гаргаж болно.	Найруулга засав.
4	6.1.12 <b>Хувьцаа эзэмшигч өөрийн төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр</b> хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулж болно. Төлөөлж оролцох этгээд энэ тухайгаа ТУЗ-д хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ.	6.1.12 Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд <b>бичгээр, эсхүл цахим хэлбэрээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно.</b> Төлөөлж оролцох этгээд энэ тухайгаа ТУЗ-д хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ.	Компанийн тухай хуулийн 2024.01.12-ны нэмэлт өөрчлөлтийн дагуу өөрчлөв.

№	Одоогийн дүрмийн заалт	Шинэчилсэн заалт	Тайлбар
5	6.2.8 ТУЗ-ийн ээлжит хурлыг <b>2 сард нэг удаа</b> хуралдуулна. Шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдааныг хэдийд ч хийж болно. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд түүнд хуралд оролцсон бүх гишүүд өөрийн хэлсэн үг, гаргасан саналын үнэн зөвийг хянан гарын үсгээ зурна.	6.2.8 ТУЗ-ийн ээлжит хурлыг <b>улиралд нэг удаа</b> хуралдуулна. Шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдааныг хэдийд ч хийж болно. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд түүнд хуралд оролцсон бүх гишүүд өөрийн хэлсэн үг, гаргасан саналын үнэн зөвийг хянан гарын үсгээ зурна.	Өөрчлөлт оруулав.
6	7.1. ТУЗ-ийн Дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, компанийн Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, газрын захирлууд, <b>хуулийн хэлтсийн дарга</b> зэрэг албан тушаалтныг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.	7.1. ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, компанийн Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, газрын захирлууд зэрэг албан тушаалтныг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.	Өөрчлөлт оруулав.
7	10.6 Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах хугацаа журмыг нийтэд болон зээлдүүлэгчид мэдээлнэ. Нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах хугацаа нийтэд мэдээлснээс хойш <b>3 сар байна.</b>	10.6 Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах хугацаа журмыг нийтэд болон зээлдүүлэгчид мэдээлнэ. Нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах хугацааг нийтэд мэдээлснээс хойш <b>хоёр сараас доошгүй, зургаан сараас дээшгүй</b> байна.	Компанийн тухай хуулийн 2024.01.12-ны нэмэлт өөрчлөлтийн дагуу өөрчлөв.
8	10.8 Нэхэмжлэл гаргах хугацаа дууссан өдрөөр тасалбар болгон компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, зээлдүүлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн <b>шаардлагын дүнг тусгасан</b> татан буулгах түр балансыг гаргах бөгөөд уг балансыг хувьцаа эзэмшигчдийн хурал батална.	10.8 Нэхэмжлэл гаргах хугацаа дууссан өдрөөр тасалбар болгон компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, зээлдүүлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн <b>шаардлагын дүнг тусгасан</b> татан буулгах түр балансыг гаргах бөгөөд уг балансыг хувьцаа эзэмшигчдийн хурал батална.	Давхардсан хэсгийг засав.

## 5.ТУЗ-ИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

### ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

#### ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



**Д.ГЭРЭЛМАА**

ТУЗ-ийн дарга,  
Эрсдэл, аудитын  
хорооны гишүүн,  
Нэр дэвшүүлэх  
хорооны гишүүн



**Д.ХҮРЭЛБААТАР**

Нэр дэвшүүлэх  
хорооны дарга,  
Цалин, урамшууллын  
хорооны дарга



**А.ЖАРГАЛМАА**

Эрсдэл, аудитын  
хорооны дарга



**Б.ЦЭЭНЯМ**

Цалин, урамшууллын  
хорооны гишүүн

#### ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮД



**Б.АМАРСАЙХАН**

Гүйцэтгэх захирал



**Ц.БААТАРСАЙХАН**

Нэр дэвшүүлэх  
хорооны гишүүн



**Н.МӨНХБАТ**

Эрсдэл, аудитын  
хорооны гишүүн



**Ц.ОРГИЛБОЛД**

Тэргүүн дэд захирал



**Д.ХУЛАН**

Цалин, урамшууллын  
хорооны гишүүн

## 2024 ОНД ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

- 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатай сонгон томилсон ба Н.Мөнхбат, Э.Пүрэвхам гишүүд ТУЗ-ийн ердийн гишүүнээр шинээр сонгогдсон.
- 2024 оны 8-р сард ТУЗ-ийн ердийн гишүүн Э.Пүрэвхам өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлснийг хүлээн авч, хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлах байдлаар зохион байгуулж, ТУЗ-ийн 2024 оны 9-р сарын 10-ны шийдвэрээр Э.Пүрэвхам гишүүнийг чөлөөлж, 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Б.Цээнъямыг түр томилсон.

### ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ, ТОМИЛОХ

Говь ХК нь компанийн дүрэмдээ заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал хураах кумулятив аргаар сонгон 3 жилийн хугацаатай томилдог.

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зүгээс ТУЗ-ийн гишүүдийн идэвх оролцоо, ажлын тайлан, гүйцэтгэлтэй танилцан, компанийн урт хугацааны стратеги төлөвлөлт, бизнесийн чиг хандлагатай уялдуулан ТУЗ-ийн гишүүдийг улираан нэр дэвшүүлэх, эсхүл бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах эсэх шийдвэрийг хэлэлцэн гаргадаг.

Говь ХК-ийн "ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам"-ын дагуу Нэр дэвшүүлэх хорооны зүгээс ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж шийдвэрлэсэн тохиолдолд ердийн болон хараат бус гишүүдийн тоо, шинээр нэр дэвшүүлэх хараат бус гишүүдийн хэрэгцээ, мэргэжил, ур чадварын нэмэлт шалгуурыг тодорхойлон, сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг. Хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг нээлттэй байдлаар, эсвэл өмнөх сонгон шалгаруулалтад оролцсон нэр дэвшигчдээс сонгон шалгаруулах гэсэн арга хэлбэрээс сонгон явуулдаг. Улмаар нэр дэвшигчдэд үнэлгээ хийн, хэлэлцэн, дүгнэлт гаргасны үндсэн дээр нэр дэвшигчдийн жагсаалтыг батлан гаргадаг.

Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгох хүртэл ТУЗ-ийн шийдвэрээр түр томилж, хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурлаар оруулж батлуулдаг. Түр томилогдсон гишүүн нь хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан байх ба ТУЗ-ийн гишүүний бүх эрх, үүргийг эдэлнэ.

### ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооноос тодорхойлон санал боловсруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг. Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин сар бүр олгох тогтмол цалин болон хурлын оролцоонд үндэслэсэн цалин гэсэн бүтэцтэй байдаг. 2024 оны 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг дараах байдлаар тогтоосон.

ТОГТМОЛ ЦАЛИН		ОРОЛЦООНД ҮНДЭСЛЭСЭН НЭМЭЛТ ЦАЛИН
Ердийн гишүүний үндсэн цалин <b>1,400,000₮</b>	Хараат бус гишүүний үндсэн цалин <b>2,800,000₮</b>	ТУЗ-ийн хурал, Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон оролцоо тутамд <b>650,000₮</b>
ТУЗ-ийн даргын албан тушаалын нэмэгдэл <b>1,000,000₮</b>		
ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга нарын албан тушаалын нэмэгдэл <b>400,000₮</b>		

### ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ЗАРЧИМ

Цалин, урамшууллын хорооны 2024 оны эхний хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалин, хангамж, урамшууллын зарчмыг дараах байдлаар тодорхойлсон.

- ТУЗ-ийн гишүүд нь компанийн санхүү, үр дүнгээс хамаарсан аливаа урамшуулал авахгүй.
- ТУЗ-ийн хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг үнэлэх зорилгоор хараат бус гишүүдийн үндсэн цалинг ердийн гишүүдийнхээс өндөр байлгана.
- Компанийн Менежмент багт ажилладаг ТУЗ-ийн ердийн гишүүд нь ТУЗ-ийн гишүүний хувьд аливаа хангамжийг давхар авахгүй.



## ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Хурал	Ээлжит хурал	Ээлжит бус хурал	Цахим санал хураалт	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал зөвлөмж	Үүрэг даалгавар	Баталсан тогтоол
ТУЗ-ийн хурал	5	5	7	55	46	18	20	41
Эрсдэл, аудитын хорооны хурал	3	1	3	19	9	7	12	4
Нэр дэвшүүлэх хорооны хурал	2	1	6	26	16	10	13	5
Цалин, урамшууллын хорооны хурал	2	-	-	14	8	6	5	1
<b>Нийт</b>	<b>12</b>	<b>7</b>	<b>16</b>	<b>114</b>	<b>79</b>	<b>41</b>	<b>50</b>	<b>51</b>

Говь ХК-ийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2024 онд нийт 12 ээлжит хурал, 7 ээлжит бус хурал, 16 цахим санал хураалт зохион байгуулж гишүүд идэвх санаачилгатай ажиллан нийт 114 асуудлыг хэлэлцэн, 79 шийдвэр гаргаж, 51 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 41 санал зөвлөмж, 50 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилт дээр нь хяналт тавьж анхаарч ажиллав. ТУЗ-ийн шийдвэрийн биелэлт 100%, удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлт 95% хэрэгжилттэй байв.

## ХУРЛЫН ИРЦ

№	ТУЗ-ийн гишүүний нэр	ТУЗ-ийн хорооны харьяалал	ТУЗ-ийн хурлын ирц	ТУЗ-ийн хорооны хурлын ирц
1	Д.Гэрэлмаа	Эрсдэл, аудитын хорооны гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	100%	100%
2	Д.Хүрэлбаатар	Нэр дэвшүүлэх хорооны дарга, Цалин, урамшууллын хорооны дарга	100%	100%
3	А.Жаргалмаа	Эрсдэл, аудитын хорооны дарга, Цалин, урамшууллын хорооны гишүүн /2024 оны 10-р сар хүртэл/	100%	100%
4	Б.Цээням	Цалин, урамшууллын хорооны гишүүн	100%	100%
5	Ц.Баатарсайхан	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	100%	100%
6	Д.Хулан	Цалин, урамшууллын хорооны гишүүн, Эрсдэл, аудитын хорооны гишүүн /2024 оны 5-р сар хүртэл/	100%	100%
7	Н.Мөнхбат	Эрсдэл, аудитын хорооны гишүүн	94%	100%
8	Б.Амарсайхан	Цалин, урамшууллын хорооны гишүүн /2024 оны 5-р сар хүртэл/	100%	100%
9	Ц.Оргилболд	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн /2024 оны 5-р сар хүртэл/	100%	100%

### Хурлын давтамж

Ээлжит хурал: ТУЗ-ийн хурал 2 сард нэг удаа буюу жилд 6 удаа (үүний нэг нь ТУЗ-ийн хараат бус гишүүдийн хурал), Эрсдэл, аудитын хорооны хурал улиралд нэг удаа буюу жилд 4 удаа, Нэр дэвшүүлэх хорооны хурал хагас жилд нэг удаа буюу жилд 2 удаа, Цалин, урамшууллын хорооны хурал хагас жилд нэг удаа буюу жилд 2 удаа хуралддаг.

Ээлжит бус хурал: ТУЗ болон хороодын ээлжит бус хурлыг ТУЗ-ийн дарга, гишүүд, компанийн Гүйцэтгэх захирал болон Менежмент багийн гишүүдийн санаачилга, шаардлагаар хэдийд ч хуралдуулж болно.



## 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Говь ХК-ийн ТУЗ нь 2024 онд 5 ээлжит хурал, 5 ээлжит бус хурал, 7 цахим санал хураалт зохион байгуулж 55 асуудлыг хэлэлцэн, 46 шийдвэр гаргаж, 41 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 18 санал зөвлөмж, 20 үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилт дээр нь хяналт тавьж чиглүүлэн ажиллав.

2024 онд ТУЗ-ийн зүгээс компанийн санхүү, үйл ажиллагаанд хяналт тавих, чиглүүлэх чиг үүргийн хүрээнд оны эхний хурал дээр компанийн бизнес төлөвлөгөөг баталж сар бүр санхүү, үр дүнгийн тайлангаар дамжуулан төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажилласан.

Энэ онд компанийн удирдлагын түвшинд томоохон өөрчлөлт орсон үйл явдал тохиолдсон нь 2008 оноос хойш Говь ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Ц.Баатарсайхан нь өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг ТУЗ-д гаргасан. Улмаар ТУЗ-ийн зүгээс дараагийн Гүйцэтгэх захирлаар томилох хүнийг хэлэлцээд Говь ХК-ийн ХБНГУ дахь охин компанийн удирдлага, Стратеги, өсөлт хөгжил хариуцсан захирлын албан тушаалыг хашиж компанийн бүхий л түвшний үйл ажиллагаа руу нарийн орж ажиллаж байгаа тул ур чадвар болон туршлагыг нь үнэлж Б.Амарсайханыг 3-р сараас эхлэн томилов.

Шинээр томилогдсон Гүйцэтгэх захирал эрч хүчтэй, шинэ үеийн төлөөлөл болсон чадварлаг удирдлагын хувьд ГОВЬ брэндийг дэлхийн зах зээлд шинээр таниулах зорилгоор rebranding хийж, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, дижитал шилжилт, эмх цэгц болон мэдээ мэдээллийн урсгалын сайжруулалт зэрэг ажлуудыг хэрэгжүүлэн компанид олон дэвшилтийг авч ирж байгаа бөгөөд ТУЗ-ийн зүгээс Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай тухай бүр танилцан, чиг удирдлагаар ханган ажиллалаа.

Говь ХК нь 2024 онд нийт компанийн хэмжээнд системийн шинэчлэлтийн ажлыг өргөжүүлэн SAP S/4 HANA ERP системийг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэх, MES (Manufacturing Execution System) болон Conveyor Belt (Дамжлагын систем)-ийг нэвтрүүлэх зэрэг томоохон ажлуудыг хэрэгжүүлж байгаагаар холбоотой ТУЗ-ийн зүгээс 1 удаагийн цахим хурал, 2 удаагийн биет хурлаар дамжуулан Мэдээлэл технологийн газрын тайлантай танилцаж, хяналт тавин, чиглүүлж ажилласан.

Компанийн засаглалын дотоод бодлогын баримт бичгүүдийг батлах чиг үүргийн хүрээнд 8-р сард Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам, 10-р сард Комплайнсын бодлогыг тус тус шинэчлэн баталсан.

Мөн БОНЗ-ын асуудлуудад нухацтай анхаарч, хяналт удирдлагаа хэрэгжүүлэн БОНЗ-ын үйл ажиллагааны тайлантай 3 удаагийн ээлжит хурлаар дамжуулан танилцаж, ТУЗ-өөс баталсан тогтвортой хөгжлийн үүрэг амлалтынхаа хэрэгжилтэд хяналт тавин, удирдлагын багийг амжилттай чиглүүлэн ажиллалаа. Энэ онд хэрэгжүүлсэн чухал ажлуудын нэг бол Тогтвортой хөгжлийн цогц бодлогыг боловсруулж эхлэн, зөвлөх компанитай хамтран ТУЗ болон Менежмент багийн түвшинд шат дараалсан сургалт, уулзалтуудыг зохион байгуулж 10-р сарын ТУЗ-ийн хурал дээр Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого, Хүний эрх, жендерийн бодлого, Нийгмийн хариуцлагын бодлогуудыг шинээр тодорхойлон баталсан.

Бид дээрх бодлогуудынхаа нийцлийг хангах, компанийн үйл ажиллагааны үе шат тус бүрт тусган хэрэгжүүлж тогтвортой хөгжлийн үйл ажиллагаагаа үнэлж дүгнэн, тасралтгүй сайжруулалтын арга хэмжээг авч ажиллах зорилгоор олон улсын чиг хандлага болон засаглалын сайн туршлагуудаас суралцан 2025 онд ТУЗ-ийн дэргэд БОНЗ-ын хороог шинээр байгуулахаар төлөвлөөд байна. ТУЗ-ийн нэгэн чухал үүрэг бол хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах, тэдний эрх ашиг зөрчигдөхөөс сэргийлэх явдал бөгөөд 2024 оны 3-р сард нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Таван Богд Холдингс ХХК нь хувьцааны эзэмшлээ нэмэгдүүлсэнтэй холбоотой Компанийн тухай хуулийн дагуу жижиг хувьцаа эзэмшигчид өөрсдийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Говь ХК-аас шаардах эрх үүссэнийг хуулийн дагуу амжилттай хэрэгжүүлсэн.





## ТУЗ-ИЙН БОЛОН ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

Говь ХК нь ТУЗ-ийн үйл ажиллагаагаа тогтмол сайжруулах зорилгоор 2015 оноос хойш жил бүр ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж байна. Мөн түүнээс гадна ТУЗ-ийн гишүүний өөрийн үнэлгээг 2018 оноос эхлэн хийж заншсан. Эдгээр үнэлгээний асуулгуудыг Нэр дэвшүүлэх хорооноос боловсруулан баталдаг бөгөөд 2024 онд СЗХ-оос боловсруулсан ТУЗ-ийн болон ТУЗ-ийн гишүүний үнэлгээний загварт суурилан, өмнөх хувилбарын асуултуудаасаа тусган, компанийн засаглалын олон улсын сайн туршлага, зарчмыг харгалзан шинэчлэн боловсруулсан.


Бид жил бүр ТУЗ-ийн болон ТУЗ-ийн гишүүний өөрийн үнэлгээг хийснээр ТУЗ-ийн үйл ажиллагаагаа дүгнэн, давуу тал болон эрсдэлтэй, сайжруулах шаардлагатай зүйлсээ тодорхойлон цаашдын төлөвлөгөөг боловсруулж, улмаар тасралтгүй сайжруулалтыг хийн ажиллаж байна.

### ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ҮНЭЛГЭЭ

2024 онд шинэчлэн боловсруулсан ТУЗ-ийн үнэлгээний асуулга нь нийт 10 бүлгийн хүрээнд 90 асуулт, нөхөж бичих 1 чөлөөт асуултаас бүрддэг.

#### ТУЗ-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН /2023-2024 он/

(2 өөр асуулга тул агуулгын хувьд харьцуулах боломжтой үзүүлэлтүүдийг харьцуулав)



2024 оны үнэлгээг агуулгаар нь авч үзвэл 10 бүлгээс 8 бүлгийг нь 2023 оны үнэлгээний дундажтай харьцуулан харах боломжтой байна. Үнэлгээний үр дүнгийн хувьд 2023 онд дундаж 94% байсан бол 2024 онд 93%-аар үнэлэгдсэн.


2024 оны үнэлгээний үр дүнгээс харахад ТУЗ-ийн дэргэдэх хороод болон ТУЗ-ийн ажлын алба бүлгүүдийн үнэлгээ буурсан байгаа нь өмнөх асуулгаар 3 хороог ерөнхийд нь үнэлдэг байсан бол одоо хороо тус бүрийн чиг үүргийг илүү задалж нарийвчлан үнэлдэг болсонтой холбоотой гэж үзэж байна. Мөн 2024 оны хувьд ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүн бүлэг 9%-ийн өсөлттэйгөөр үнэлэгдсэн нь хамгийн өндөр өсөлт болсон байна.



## ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ 2024 ОНЫ ҮНЭЛГЭЭ

2024 онд шинэчилсэн ТУЗ-ийн гишүүний үнэлгээ нь ТУЗ-ийн гишүүний үүрэг, оролцоотой холбоотой 28 асуулт, ТУЗ-ийн үйл ажиллагаа болон компанийн үйл ажиллагаатай холбоотой өөрийн санаачилж хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнтэй холбоотой нөхөж бичих 2 чөлөөт асуултаас бүрддэг.

### ТУЗ-ийн гишүүний үнэлгээний дундаж /2023-2024 он/



ТУЗ-ийн гишүүд өөрсдийгөө жил бүр үнэлснээр өөрийн давуу болон сул талыг олж харах, цаашид анхаарч ажиллах үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлж дүгнэхээс гадна Нэр дэвшүүлэх хорооны зүгээс ТУЗ-ийн гишүүдийнхээ үйл ажиллагааг дүгнэх нэгэн үзүүлэлт болдог. 2024 оны хувьд ТУЗ-ийн гишүүдийн шинэчилсэн өөрийн үнэлгээний дундаж 92% болж өмнөх оноос 3% өссөн үр дүнтэй байна.

### ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ОРОЛЦОО

Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүд нь оны эхэнд тухайн жилд анхаарч ажиллах чиглэлээ тодорхойлдог бөгөөд оны эцэст компанийн болон ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой өөрийн санаачилж хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээ дүгнэн хэлэлцдэг. Бид ТУЗ-ийн хараат бус гишүүдийнхээ оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2022 оноос эхлэн хараат бус гишүүдийн хурлыг жилд 1 удаа тогтмол зохион байгуулж байгаа ба 2024 оны хурлыг 2025 оны 1-р сард зохион байгуулж, үйлдвэрт шинээр нэвтрүүлсэн систем, дамжлагуудтай нарийн танилцаж, компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хараат бусаар хэлэлцэн, үйл ажиллагаанд саналаа тусган ажилласан.



# ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ТАЙЛАН



## НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

### Зорилго

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь ТУЗ-ийг Эрх бүхий албан тушаалтнууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад Менежмент багийн удирдлагуудын залгамж халааны тогтвортой байдлыг хангах, тэдгээрийн ажил үүргийн тодорхойлолт, гэрээний нөхцөлийг тодорхойлох, ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч хяналт тавин, чиг удирдлагаар хангах гэсэн үндсэн чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино. Мөн тус хороо нь ЭБАТ-уудтай холбоотой шүгэл үлээх системээр ирүүлсэн мэдээллийг шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

### Бүрэлдэхүүн

Бүрэлдэхүүн	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	ТУЗ-ийн гишүүний нэр
Хорооны дарга	Хараат бус гишүүн	Д.Хүрэлбаатар
Гишүүд	Хараат бус гишүүн	Д.Гэрэлмаа
	Ердийн гишүүн	Ц.Баатарсайхан

### Хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт:

2024 оноос эхлэн хороодын гишүүний бүрэлдэхүүнийг томилохдоо компанийн Менежмент багт ажилладаггүй ТУЗ-ийн гишүүдийг томилох зарчмыг баримталж эхэлсэн тул ТУЗ-ийн 2024 оны 5-р сарын 21-ны №24 тоот тогтоолоор тус хорооны гишүүн Ц.Оргилболдын оронд ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Баатарсайханыг томилж.

### 2024 оны ажлын тайлан

Нэр дэвшүүлэх хороо нь 2024 онд 2 ээлжит хурал, 1 ээлжит бус хурал, 6 цахим санал хураалт зохион байгуулж, 26 асуудлыг хэлэлцэн, 16 шийдвэр гаргав. Хорооны чиг үүргийнхээ хүрээнд 10 төрлийн санал зөвлөмж, 13 үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтнуудад өгч, хяналт тавьж ажилласан бөгөөд 5 тогтоол батлав. Тус хорооны шийдвэрийн биелэлт 100%, удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлт 100% хэрэгжилттэй байв.

- Компанийн ЭБАТ-уудын залгамж халааны тогтвортой байдлыг хангах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:
  - Гүйцэтгэх захирал чөлөөлөгдөх хүсэлт өгсөнтэй холбоотой хүсэлтийг хүлээн авч, шинээр томилох Гүйцэтгэх захирал дээр санал боловсруулан 2024 оны 2-р сарын 28-ны ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн томилсон.
  - Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс албан бичгээр ирүүлсэн “ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид санал оруулах тухай” хүсэлтийг хүлээн авч “ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрсийг тодорхойлон баталж, 4-р сарын хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатай сонгон томилж.
  - ТУЗ-ийн ердийн гишүүнээс 8-р сард чөлөөлөгдөх хүсэлт ирүүлснийг хүлээн авч, хуулийн дагуу 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл хараат бус гишүүнийг түр томилохоор шийдвэрлэсэн. Улмаар ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлах байдлаар зохион байгуулж, 2024 оны 9-р сарын 10-ны ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн томилсон.
- ЭБАТ-уудын ажил үүргийн тодорхойлолт, гэрээний нөхцөлийг тодорхойлон хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:
  - Шинээр томилогдсон Гүйцэтгэх захирлын эрх, үүргийн хэмжээг хэлэлцэн, Менежментийн гэрээний нөхцөлийг шинэчлэн ТУЗ-ийн хурлаар гэрээний загварыг батлуулж, Гүйцэтгэх захиралтай гэрээг байгуулсан.
  - Хагас жилийн хорооны хурал дээр Менежмент багийн удирдлагуудын ажил үүргийн чиглэл, гэрээний нөхцөл, хэрэгжилтийн талаар танилцаж Хүний нөөц хариуцсан захирлыг чиг удирдлагаар хангаж ажилласан.

- ТУЗ-ийн гишүүдийн хууль, дүрэм журмын дагуу хэрэгжүүлэх эрх үүргийн матрицыг хэлэлцэж, цаашид тогтмол сайжруулан, хэрэгжилтийг ханган ажиллахаар шийдвэрлэв.
- ЭБАТ-уудын ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч хяналт тавин, удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:
  - Оны эхний хурлаар Менежмент багийн удирдлагуудын 2023 оны ажлын тайлантай танилцаж, тус тайланд Гүйцэтгэх захирлаас өгсөн дүгнэлттэй танилцан үйл ажиллагаа сайжруулах зөвлөмжийг өгөв. Менежмент багийнхны жилийн тайлан болон гүйцэтгэлд үндэслэн хамт олноо манлайлан удирдаж, амжилттай ажилласан хоёр удирдлагыг ТУЗ-ийн нэрэмжит шагналд нэр дэвшүүлэн, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шагнав.
  - Хагас жилийн хурлаар Гүйцэтгэх захирлын ажлын тайлантай танилцаж, хяналт удирдлагын үүргээ хэрэгжүүлэв. Мөн Гүйцэтгэх захирлын жилийн эцсийн үр дүнг дүгнэх зорилгоор тайлангийн загварыг боловсруулсан бөгөөд 2025 оны 1-р сарын хурлаар ажлын үр дүнтэй танилцана.
  - Тус хурлаар компанийн “Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэх төслийг хэлэлцэн, 2024 оны 8-р сарын 9-ний ТУЗ-ийн хурлаар батлуулсан. Энэхүү журмын хэрэгжилтийг ханган, компанийн шүгэл үлээх системээр ЭБАТ-уудтай холбоотой ирсэн мэдээллийг тухай бүр шийдвэрлэн холбогдох удирдлагуудад санал зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавруудыг өгч хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.
  - 2024 онд ТУЗ-ийн өөрийн үнэлгээ болон ТУЗ-ийн гишүүний өөрийн үнэлгээний асуулгыг шинэчлэн үнэлгээг хийсэн.

## ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

### Зорилго

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь ТУЗ-ийг Эрх бүхий албан тушаалтнууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад Менежмент багийн удирдлагуудыг цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, Компанийн хэмжээнд баримтлах Цалин, урамшууллын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Бүрэлдэхүүн	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	ТУЗ-ийн гишүүний нэр
Хорооны дарга	Хараат бус гишүүн	Д.Хүрэлбаатар
Гишүүд	Хараат бус гишүүн	Б.Цээням
	Ердийн гишүүн	Д.Хулан

### Хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт:

2024 оноос эхлэн хороодын гишүүний бүрэлдэхүүнийг томилохдоо компанийн Менежмент багт ажилладаггүй ТУЗ-ийн гишүүдийг томилох зарчмыг баримталж эхэлсэн тул ТУЗ-ийн 2024 оны 5-р сарын 21-ны №24 тоот тогтоолоор тус хорооны гишүүн Б.Амарсайханы оронд ТУЗ-ийн ердийн гишүүн Э.Пүрэвхамыг томилж. Мөн 9-р сард ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотой ТУЗ-ийн 2024 оны 10-р сарын 30-ны №34 тоот тогтоолоор тус хорооны гишүүн А.Жаргалмаа, Э.Пүрэвхам нарын оронд ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Цээням, ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хулан нарыг томилж.

### 2024 оны ажлын тайлан

Цалин урамшууллын хороо нь 2024 онд 2 ээлжит хурал зохион байгуулж, 14 асуудлыг хэлэлцэн, 8 шийдвэр гаргав. Хорооны чиг үүргийнхээ хүрээнд 6 төрлийн санал зөвлөмж, 5 үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтнуудад өгч, хяналт тавьж ажилласан бөгөөд 1 тогтоол батлав. Тус хорооны шийдвэрийн биелэлт 100%, удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлт 100% хэрэгжилттэй байв.

- ЭБАТ-уудын цалин, урамшууллын бодлогыг тодорхойлон, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:
  - Оны эхний хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалин, хангамж, урамшууллын зарчмыг хэлэлцэн батлав. Ингэснээр Менежмент багт ажилладаг ТУЗ-ийн ердийн гишүүд, бусад ердийн гишүүд болон хараат бус гишүүдийн цалин, хангамж, урамшууллыг тогтооход баримтлах тодорхой зарчимтай болсон.



- ТУЗ-ийн хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг үнэлэх зорилгоор хараат бус гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх санал боловсруулж 2024 оны 4-р сарын хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлуулахаас гадна 2024 оны ТУЗ-ийн цалингийн төсвийг нээлттэй хэлэлцэн батлуулсан.
- ЭБАТ-уудын цалин урамшууллын гүйцэтгэлтэй хагас жил тутам танилцаж ажилласан бөгөөд хагас жилийн хурлаар ЭБАТ-уудын урамшууллын зарчимтай танилцахаас гадна Гүйцэтгэх захирлын цалингийн хэмжээг хэлэлцэн шинэчлэн тогтоосон.

Компанийн хэмжээнд баримтлах цалин, урамшууллын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тодорхойлон, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийнхээ хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Оны эхний хурлаар компанийн Цалин урамшууллын бодлогыг шинэчлэх төслийг хэлэлцэн 2024 оны 1-р сарын 26-ны ТУЗ-ийн хурлаар батлуулав.
- Мөн тус хурлаар компанийн 2023 оны цалин урамшууллын гүйцэтгэлд хяналт тавьж, 2024 оны төсвийг хэлэлцэн бизнес төлөвлөгөөнд тусган ТУЗ-өөр батлуулсан.
- Байгууллагын соёлын судалгаа, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, түүнийг сайжруулах чиглэлээр хийгдсэн ажлуудтай танилцаж удирдлагыг чиг удирдлагаар хангасан.

## ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРОО

### Зорилго

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавих, чиглүүлэх, дотоод хяналт, комплаинс болон эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавих, чиглүүлэх, хараат бус аудитын байгууллагатай харилцан, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжоор хангах гэсэн үндсэн 3 чиг үүргийг хэрэгжүүлж ТУЗ-ийг эрсдэлийн удирдлага болон компанийн үйл ажиллагаа дахь хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Бүрэлдэхүүн	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	ТУЗ-ийн гишүүний нэр
Хорооны дарга	Хараат бус гишүүн	А.Жаргалмаа
Гишүүд	Хараат бус гишүүн	Д.Гэрэлмаа
	Ердийн гишүүн	Н.Мөнхбат

### Хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт:

2024 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотой ТУЗ-ийн 2024.05.21-ны №24 тоот тогтоолоор тус хорооны гишүүн Д.Хулангийн оронд ТУЗ-ийн ердийн гишүүн Н.Мөнхбатыг томилов.

### 2024 оны ажлын тайлан

Эрсдэл, аудитын хороо нь 2024 онд 3 ээлжит хурал, 1 ээлжит бус хурал, 3 цахим санал хураалт зохион байгуулж, 19 асуудлыг хэлэлцэн, 9 шийдвэр гаргав. Хорооны чиг үүргийнхээ хүрээнд 7 төрлийн санал зөвлөмж, 12 үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтнуудад өгч, хяналт тавьж ажилласан бөгөөд 4 тогтоол батлав. Тус хорооны шийдвэрийн биелэлт 100%, удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлт 83% хэрэгжилттэй байв.

- Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны хяналтын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:
  - Компанийн улирал болон хагас жилийн санхүүгийн тайлангуудтай танилцан дүгнэж, олон нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд хяналт тавьсан.
  - Улирал бүрийн хурлаар дамжуулан сонирхлын зөрчилтэй болон холбоотой талуудтай хийгдсэн гүйлгээний гүйцэтгэлтэй танилцан ТУЗ-ийн 2024 оны 1-р сарын 26-ны хурлаар баталсан холбоотой талуудтай хийх гүйлгээний төсвийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.
- Компанийн дотоод хяналт, комплаинс, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:



- Дотоод аудитын хэлтсийн ажлын тайлантай улирал бүр танилцаж компанийн хэмжээнд хийгдсэн дотоод аудитын ажлын үр дүнтэй танилцан дотоод хяналтын чиг үүргээ хэрэгжүүлсэн.
- Говь ХК нь 2024 оноос Нийцлийн газартай болсон бөгөөд тус газрын тайлантай хагас жил тутам танилцаж үйл ажиллагааг төлөвшүүлэх, үр дүнтэй байдлыг хангахад чиг удирдлагаар ханган ажилласан. Мөн 3-р улирлын хурал дээр Комплаинсын бодлогыг шинэчлэх төслийг хэлэлцэн 2024 оны 10-р сарын 30-ны ТУЗ-ийн хурлаар батлуулсан.
- Хагас жилийн хурлаар эрсдэлийн удирдлагын багийн ажлын тайлан, эрсдэлийн үнэлгээ болон мониторингийн үр дүнтэй танилцаж удирдамжаар ханган ажилласан. Мөн “Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор боловсруулж буй Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны төлөвлөгөөний явцтай танилцан санал зөвлөмжийг өгсөн.

Хараат бус аудитын байгууллагатай харилцах, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжоор хангах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Оны эхний хурал дээр 2023 хараат бус аудиторын дүгнэлт зөвлөмжтэй танилцаж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.
- 2023 оны тусдаа буюу охин компаниуд ороогүй санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагын сонгон шалгаруулалттай танилцан санал өгч 2024 оны 4-р сарын 19-ний ТУЗ-ийн хурлаар сонгов.
- 2024 оны хөндлөнгийн аудиторын сонгон шалгаруулалтад хорооны гишүүдийн зүгээс хараат бус байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийж, үнийн саналтай танилцан санал өгч 2024 оны 9-р сарын 10-ны ТУЗ-ийн хурлаар сонгов.
- 11-р сард ээлжит бус хурлаар 2024 оны хөндлөнгийн аудитын төлөвлөгөөтэй танилцан, бэлтгэл ажлыг хангахтай холбоотой зөвлөмж үүрэг даалгаврыг холбогдох удирдлагуудад өгсөн.


## 6. ТУЗ-ИЙН 2025 ОНЫ ЦАЛИНГИЙН ТӨСӨВ

/төгрөг/

Агуулга	2024 он			2025 он		
	Төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэл %	Төсөв	2025Т/2024Т өөрчлөлт	Өөрчлөлт %
Тогтмол цалин	211,200,000	213,533,333	1%	237,200,000	26,000,000	12%
Оролцооны цалин	50,700,000	44,200,000	-13%	59,150,000	8,450,000	17%
НДШ	30,118,500	27,371,050	-9%	32,598,500	2,480,000	8%
<b>Нийт цалин</b>	<b>292,018,500</b>	<b>285,104,383</b>	<b>-2%</b>	<b>328,948,500</b>	<b>36,930,000</b>	<b>13%</b>

## 7. ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 2025 оны 3-р сарын 17-ны өдрийн №02 тоот тогтоолоор 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн бүрэлдэхүүнд дараах нэр дэвшигчдийг нэр дэвшүүлэхээр шийдвэрлэсэн.



**"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ**  
**НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ**  
**ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 17 өдөр      Дугаар 02      Улаанбаатар хот

Г ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай Г

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг хэлэлцэн, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 66-р зүйлийн 66.1, 66.3, 66.4, 66.5, 81-р зүйлийн 81.5.2, 81.5.3-р заалт, Говь ХК-ийн "ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам" болон тус хорооны дүрмийг үндэслэн Нэр дэвшүүлэх хорооны хурлаас **ТОГТООХ нь:**

- Говь ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн бүрэлдэхүүнд дараах нэр дэвшигчдийг нэр дэвшүүлсүгэй.
 


ТУЗ-ийн хараат бус гишүүнд:

  - Дамбын ГЭРЭЛМАА
  - Алтангэрэлийн ЖАРГАЛМАА
  - Дамбийжавын ХҮРЭЛБААТАР нарыг улируулан нэр дэвшүүлэх

ТУЗ-ийн ердийн гишүүнд:

  - Баатарсайханы АМАРСАЙХАН
  - Цагаачийн БААТАРСАЙХАН
  - Цогтгэрэлийн ОРГИЛБОЛД
  - Дашдаваагийн ХУЛАН нарыг улируулан нэр дэвшүүлэх
  - Батжаргалын ОРГИЛ
  - Баатарсүрэнгийн ЦЭЭНЯМ нарыг шинээр нэр дэвшүүлэх
- Энэхүү шийдвэрийг Нэр дэвшүүлэх хорооны саналын эрхтэй ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДАРГА  
ГИШҮҮД



Д ХҮРЭЛБААТАР  
Д.ГЭРЭЛМАА

"Говь" ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот Т7062, Монгол улс  
 Утас: 976-70139977, Факс: 976-70143081, И-мэйл: info@gobi.mn, Вэб сайт: www.gobi.mn





## ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА



**Д.ГЭРЭЛМАА**

**МЭРГЭЖИЛ**  
Эдийн засагч

**БОЛОВСРОЛ**  
1982-1988

ЗХУ, Москва хотын Цахилгаан Холбооны Дээд Сургууль, Холбооны инженер эдийн засагч, бакалавр

2000-2003

МУ-ын ЗГ-ийн хэрэгжүүлэгч агентлаг "Удирдлагын академи", удирдахуйн ухааны доктор

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

1988-1992

Радио Телевизийн Техникийн Төв, эдийн засагч

1992-1994

Эдийн Засгийн Хөгжлийн Коллеж, Бизнес удирдлагын тэнхим, Багш

1994-2003

Эдийн Засгийн Хөгжлийн Коллеж, Бизнес удирдлагын тэнхим, Тэнхимийн эрхлэгч

2003-2006

Монгол Улсаас НҮБ-д суух Байнгын төлөөлөгчийн газар, Швейцарийн Холбооны улс дахь ЭСЯ, Нягтлан бодогч

2006-2009

СЭЗИС, Сургалт Эрдэм Шинжилгээ эрхэлсэн дэд захирал

2009-2015

СЭЗИС, Сургалт эрхэлсэн дэд захирал

2015 оноос

СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессор

2022 оноос

СЭЗИС, Ахисан Түвшний сургуулийн профессор

2013 оноос

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**

Хувьцаа эзэмшдэггүй.



**А.ЖАРГАЛМАА**

**МЭРГЭЖИЛ**

Нягтлан бодогч

**БОЛОВСРОЛ**

2008-2012

Oxford Brookes Их Сургууль, Нягтлан бодох бүртгэл, бакалавр

2010-2012

ACCA Мэргэшлийн түвшний шалгалтууд, (Association of Chartered Certified Accountants)

2012-2015

Санхүү Эдийн Засгийн Их сургууль, Бизнесийн удирдлага, магистр

2013-2015

Хандонг Глобал Их Сургууль, Глобал менежмент, MBA

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2012-2017

Багш, Санхүү Эдийн Засгийн их сургууль

2013-2014

Итезмон ХХК, Нягтлан бодогч

2014-2014

Иаруди Консалтинг ХХК, Зөвлөх

2016-2018

Бурый мэдвэдь ХХК, Нягтлан бодогч

2015-оноос

Дүнгээ ХХК, Нягтлан бодогч

2017 оноос

GAPE (Global Academy for Professional Education), ACCA ахлах багш, хөтөлбөрийн удирдагч

2019 оноос

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**

Хувьцаа эзэмшдэггүй.



**Д.ХҮРЭЛБААТАР**

**МЭРГЭЖИЛ**

Нягтлан бодогч, Эдийн засагч, Санхүүч

**БОЛОВСРОЛ**

1979-1981

Худалдааны Техникум, Нягтлан бодогч, бакалавр

1985-1989

ОХУ-ын Байгалийн Улсын Их сургууль (Иркутск хотын УАААДС), Эдийн засагч, санхүүч магистр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

1981-1984

Улсын банк, Улсын байцаагч аудитор

1990-2005

Худалдаа Хөгжлийн Банк, Харилцагчийн үйлчилгээний газрын захирал

2005-2007

Монгол шуудан банк, Дэд захирал

2008-2016

Говь ХК, ТУЗ-ийн гишүүн

2007-2020

Худалдаа Хөгжлийн Банк, Гүйцэтгэх захирлын орлогч

2020-2022

Худалдаа Хөгжлийн Банк, ТУЗ-ийн ажлын албаны дарга

2022 оноос

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**

4,800 ширхэг (0.0006%)

## ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА



**Б.АМАРСАЙХАН**

**МЭРГЭЖИЛ**

Бизнесийн удирдлага ба энтерпренершип

**БОЛОВСРОЛ**

2016 - 2019

Их Британи улс, Westminster Их Сургууль, Бизнесийн удирдлага ба энтерпренершип, бакалавр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2019-2023

Говь Кашмер Европ ХХК, Гүйцэтгэх захирал

2022 оноос

Говь Кашмер Их Британи ХХК, Гүйцэтгэх захирал

2022-2024

Говь ХК, Стратеги, өсөлт хөгжил хариуцсан захирал

2022 оноос

Таван Богд Холдингс ХХК, Стратеги, бизнес хөгжил хариуцсан захирал

2023 оноос

Говь Кашмер Казахстан ХХК, Говь Кашмер Америк ХХК, Говь Кашмер Өвөр Монгол ХХК, Гүйцэтгэх захирал

2024 оноос

Говь ХК, Гоёо ХХК, Гүйцэтгэх захирал, Говь Австрали салбарын захирал

2023 оноос

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**

Хувь хүн: 1,000 ширхэг (0.0001%)

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 681,267,736 ширхэг (87.33%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



**Ц.БААТАРСАЙХАН**

**МЭРГЭЖИЛ**  
Инженер

**БОЛОВСРОЛ**  
1984-1988

Монгол улс, Политехникийн Их Сургууль, Холбооны инженер, бакалавр

1989-1993

Япон улс, Токио хотын Цахилгаан Холбоо, Электроникийн Их Сургууль, Электроникийн инженер, бакалавр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

1993-1997

Япон Монголын хамтарсан Алтай ХХК, Гүйцэтгэх захирал

1997 оноос

Таван Богд Группийн Ерөнхийлөгч, Таван Богд Холдингс ХХК-ийн Ерөнхий захирал,

2001-2003

МИАТ компани, Дэд ерөнхийлөгч

2008-2024

Говь ХК, Гүйцэтгэх захирал

2009 оноос

Хаан Банк ХК, ТУЗ-ийн гишүүн

2007 оноос

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**

Хувь хүн: 50,000 ширхэг (0.006%)

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 681,267,736 ширхэг (87.33%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



**Ц.ОРГИЛБОЛД**

**МЭРГЭЖИЛ**

Олон улсын харилцаа

**БОЛОВСРОЛ**

2011-2014

Япон улс, Temple Их Сургууль, Олон улсын харилцаа, бакалавр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2014

Эдийн засгийн хөгжлийн яам, Чөлөөт бүс хариуцсан мэргэжилтэн

2016

Таван Богд Холдингс ХХК, Бизнес хөгжлийн менежер

2016-2017

Жуулчин Дюти Фрий ХК, Гүйцэтгэх захирал

2017-2019

Гоёо ХХК, Гүйцэтгэх захирал

2019-2021

Говь ХК, Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал

2021-2022

Саппорт Сервисес Монголиа ХХК, Дэд захирал

2022-2023

Говь ХК, Тэргүүн дэд захирал /Дизайн, үйлдвэрлэл, дэмжих/

2023-2025

Говь ХК, Тэргүүн дэд захирал /Гадаад, экспортын борлуулалт/

2023 оноос

Говь Кашмер Европ ХХК, Гүйцэтгэх захирал

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**

Хувь хүн: Хувьцаа эзэмшдэггүй.

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 681,267,736 ширхэг (87.33%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



**Д.ХУЛАН**

**МЭРГЭЖИЛ**

Олон улсын банк санхүү

**БОЛОВСРОЛ**

1985-1990

Орос улс, Москвагийн Санхүүгийн Дээд Сургууль, Олон улсын банк санхүү, бакалавр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

1990-1992

Монгол Улсын Сангийн Яам, Эдийн засгийн гадаад харилцааны хэлтэс, Эдийн засагч

1993-1997

Говь ХК, Токио дахь салбар, Төлөөлөгч, худалдааны менежер

1997-2000

Таван Богд Холдингс ХХК, Дэд захирал

2000-2002

Худалдаа Хөгжлийн Банк, Дэд захирал

2003-2021

Таван Богд Групп, Тэргүүн дэд ерөнхийлөгч

2003-2021

Хаан Банк ХК, ТУЗ-ийн гишүүн

2009 оноос

Люксембург улсын Монгол дахь өргөмжит консул

2021 оноос

Хаан Банк ХК, ТУЗ-ийн дэд дарга

2021 оноос

Таван Богд Групп, ТУЗ-ийн дарга

2007 оноос

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**

Хувь хүн: 12,973,022 ширхэг (1.66%)

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 681,267,736 ширхэг (87.33%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)

**МЭРГЭЖИЛ**

Санхүүгийн удирдлага

**БОЛОВСРОЛ**

2006-2011

Бүгд Найрамдах Турк Улс, Bogazici University, Олон улсын худалдаа, санхүү, бакалавр

2012-2015

Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Санхүүгийн менежмент магистр CFA Level 2

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2011-2012

СББ Трейд ХХК, Мэргэжилтэн

2012-2013

Эрдэнэс Оюу Толгой ХХК, Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн

2013-2018

Монголын Төмөр Зам ТӨХК, Эдийн засгийн албаны менежер

2018-2022

Иргэний Нисэхийн Ерөнхий Газар, Эдийн засгийн зохицуулалтын тасгийн дарга

2022-2024

НУБИЭ ХХК, Зөвлөх

2025 оноос

Таван Богд Холдингс ХХК, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**

Хувь хүн: Хувьцаа эзэмшдэггүй.

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 681,267,736 ширхэг (87.33%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



**Б.ЦЭЭНЯМ**

**МЭРГЭЖИЛ**  
Маркетингийн менежмент

**БОЛОВСРОЛ**  
2014-2018 Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Маркетингийн менежмент, бакалавр  
2022-2023 АНУ, Lindenwood Их Сургууль, Бизнесийн удирдлага, магистр

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**  
2018-2021 Таван Богд Холдингс ХХК, Маркетингийн газар, Судалгааны менежер  
2023-2025 АНУ, Anand Resource компани, Ерөнхий менежер  
2025 оны 3-р сараас Таван Богд Холдингс ХХК, Дотоод аудит хариуцсан дэд захирал  
2024 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**  
Хувьцаа эзэмшдэггүй.



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСӨЛ

Төсөл

### ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4-р сарын 25-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

*Компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.9.10 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн 2024 оны санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2025 оны 4-р сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Говь ХК-ийн 2024 оны санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралт 1-ээр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



**ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 4-р сарын 25-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

*Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг  
батлах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 62 дугаар зүйлийн 62.1.1, Компанийн дүрмийн 6.1.9.1 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон 2025 оны 4-р сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Говь ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Хавсралт 1-ээр баталсугай.
2. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг тусгасан шинэчлэн найруулгыг хуульд заасан журмын дагуу Улсын бүртгэлд итгэмжлэлгүйгээр төлөөлөн бүртгүүлэхийг Хуулийн хэлтсийн дарга /Ц.Цасчихэр/-т даалгасугай.
3. Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, шинэчлэн найруулсан дүрмийг Улсын бүртгэл бүртгэсэн өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа дагаж мөрдөн, хэрэгжилтийг ханган ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д үүрэг болгосугай.

**ХУРЛЫН ДАРГА**



**ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 4-р сарын 25-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны  
цалингийн төсвийг батлах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, Компанийн дүрмийн 6.1.9.12 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2025 оны 4-р сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны цалингийн төсвийг дараах байдлаар баталсугай.

Агуулга	2024 он		2025 он	
	Төсөв	Төсөв	Өөрчлөлт	
			төгрөг	хувь
Тогтмол цалин	211,200,000	237,200,000	26,000,000	12%
Оролцооны цалин	50,700,000	59,150,000	8,450,000	17%
НДШ	30,118,500	32,598,500	2,480,000	8%
<b>Нийт цалин</b>	<b>292,018,500</b>	<b>328,948,500</b>	<b>36,930,000</b>	<b>13%</b>

2. Батлагдсан төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Цалин, урамшууллын хороонд үүрэг болгосугай.

**ХУРЛЫН ДАРГА**





**ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 4-р сарын 25-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг  
сонгон томилох тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4, Компанийн дүрмийн 6.1.9.8, 6.2.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2025 оны 4-р сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийн хугацааг дуусгавар болгосугай.
2. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Дамбын ГЭРЭЛМАА  
Алтангэрэлийн ЖАРГАЛМАА  
Дамбийжавын ХҮРЭЛБААТАР нарыг;

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:


Баатарсайханы АМАРСАЙХАН  
Цагаачийн БААТАРСАЙХАН  
Цогтгэрэлийн ОРГИЛБОЛД  
Дашдаваагийн ХУЛАН  
Батжаргалын ОРГИЛ  
Баатарсүрэнгийн ЦЭЭНЯМ нарыг тус тус 3 жилийн хугацаагаар сонгон томилсугай.

**ХУРЛЫН ДАРГА**



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2025 оны 03-р сарын 14-ний өдрийн хурлын  
04-р тогтоолын 7-р хавсралт



**ГОВЬ ХК-ИЙН 2025 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС**

<b>Комиссын дарга</b>	Дотоод аудитын хэлтсийн дарга	Н.Сайнзул
<b>Комиссын гишүүд</b>	Үйлдвэр бүртгэлийн албаны дарга	Ц.Цэцэгбадам
	Хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга	Б.Уянга
	Нягтлан бодогч	Б.Ууганзаяа
	Нягтлан бодогч	Б.Урангоо
<b>Комиссын нарийн бичиг</b>	Аудитын менежер	Д.Сарангуа

# САНАЛ АВАХ ХУУДАСНЫ ЗАГВАР

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2025 оны 03 сарын 14-ний өдрийн хурлын  
04-р тогтоолын 3-р хавсралт



## “ГОВЬ” ХК-ИЙН 2025 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хурлын өдөр: 2025 оны 4-р сарын 25-ны өдөр

Эхлэх цаг: 14:00 цаг

Байршил: ХААН театр

(Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж-25, Хаан банкны  
Сүүл оффисын 1 давхар)

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ:

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:	
Регистрийн дугаар:	
Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо:	
Утасны дугаар:	
И-мэйл хаяг:	

### 1-Р ХЭСЭГ. САНАЛ ХУРААХ АРГА: ЭНГИЙН АРГА

№	Шийдвэр гаргаж, батлах асуудал	Хурлаас гаргах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1	Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах	<b>ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай</b>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
2	Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах	<b>Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай</b>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
3	ТУЗ-ийн 2025 оны цалингийн төсвийг батлах	<b>2025 оны цалингийн төсвийг батлах тухай</b>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

### Энгийн аргаар санал өгөх заавар:

- Саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож (✓ эсвэл +) тэмдэг тавина.
- Жишээ нь: зөвшөөрсөн бол “Зөвшөөрсөн” гэсэн нүдэнд (✓ эсвэл +), татгалзсан бол “Татгалзсан” гэсэн нүдэнд (✓ эсвэл +), түдгэлзсэн бол “Түдгэлзсэн” гэсэн нүдэнд (✓ эсвэл +) тэмдэг тавина.
- Хэрэв татгалзсан бол “Таны өгөх санал” гэсэн нүдэнд уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх саналтай байгаагаа бичнэ.
- Хүчингүй саналын хуудас: Засварласан, балласан, (✓ эсвэл +)-ээс өөр тэмдэглэгээ хэрэглэсэн, нэгээс олон санал бөглөсөн болон аль нэг саналыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.

### 2-Р ХЭСЭГ. САНАЛ ХУРААХ АРГА: КУМУЛЯТИВ АРГА

Нийт кумулятив саналын тоо: .....

#### 1. ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчийг сонгох

№	Нэр дэвшигчийн овог, нэр	Кумулятив саналын тоо
1	Дамбын ГЭРЭЛМАА	
2	Алтангэрэлийн ЖАРГАЛМАА	
3	Дамбийжавын ХҮРЭЛБААТАР	

#### 2. ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчийг сонгох

№	Нэр дэвшигчийн овог, нэр	Кумулятив саналын тоо
1	Баатарсайханы АМАРСАЙХАН	
2	Цагаачийн БААТАРСАЙХАН	
3	Цогтгэрэлийн ОРГИЛБОЛД	
4	Дашдаваагийн ХУЛАН	
5	Батжаргалын ОРГИЛ	
6	Баатарсүрэнгийн ЦЭЭНЯМ	

### Кумулятив аргаар санал өгөх заавар:

- Кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн 1 хувьцаа нь 9 кумулятив саналын эрхтэй байна.
- Хувьцаа эзэмшигч нь нийт кумулятив саналын эрхээ нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нь 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг бол кумулятив аргаар санал өгөх нийт 900 саналын эрхтэй /100 хувьцаа х 9 гишүүн = 900 санал/ болно.

Хувьцаа эзэмшигч А нь 900 саналын эрхээ бүгдийг нь ТУЗ-ийн ердийн ба хараат бус гишүүнээс үл хамааран өөрийн сонгосон аль нэг нэр дэвшигчид өгч болно. Эсвэл хэд хэдэн нэр дэвшигчдэд тус тус дурын харьцаагаар хуваарилан өгч болно.

### Санамж:

- Урьдчилан санал өгөх:** Саналын хуудсыг бөглөж дараах арга хэлбэрээр 2025 оны 4-р сарын 22-ны өдрийн дотор иргэний үнэмлэх (хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ)-ний хуулбарын хамт ирүүлнэ үү:
  - Өөрийн харилцдаг үнэт цаасны компаниар дамжуулан өгөх;
  - Говь ХК дээр биечлэн ирж өгөх;
  - Шуудангаар илгээх: Монгол Улс, УБ-17062, Шуудангийн хайрцаг-36/434, “Говь” ХК);
  - И-мэйлээр ирүүлэх: boardoffice@gobicashmere.com
- Та урьдчилан санал өгсөн тохиолдолд дахин санал өгөх эрхгүй болно.**
- Төлөөлүүлэн санал өгөх:** Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгөн, нотариатаар баталгаажуулсан байх шаардлагатай.

Огноо: 2025 оны ... -р сарын ... -ны өдөр

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг .....

### Тооллогын комисс бөглөх хэсэг:

Хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн дугаар	Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх	Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан
	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	

GOBI 

"ГОВЬ" ХК,  
ҮЙЛДВЭРИЙН ГУДАМЖ, 3-Р ХОРОО, ХАН-УУЛ ДҮҮРЭГ,  
УЛААНБААТАР-17062, МОНГОЛ УЛС, Ш/Х 36/434

УТАС: +976 7013-9977, ФАКС: +976 7014-3081  
И-МЭЙЛ: INFO@GOBI.MN